МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ 2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ

№	Баримтын агуулга	Хуудас
1.	**Хуралдааны товч тэмдэглэл:**	1-7
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	8-69
	1.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	12-22
	2.Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	22-45
	3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	45-56
	4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	56-59
	5.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	59-64
	6.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	64-67
	7.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрөөс олгох урамшуулласан нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/	67-68
	8.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 01 дүгээр сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	68-69

ХУРАЛДААНЫ ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

Хоёр.Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд */Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн,* ***хэлэлцэх эсэх****/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн газрын ахлах шинжээч С.Орхон, Б.Гэрэлсайхан, ахлах мэргэжилтэн Ө.Бодьгэрэл, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг, мөн газрын Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, М.Оюунчимэг, Б.Саранчимэг, Ж.Чинбүрэн, С.Одонтуяа, Ц.Туваан, Б.Жаргалмаа, С.Чинзориг нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Бейсен, Ц.Туваан нар үг хэлэв.

П.Анужин: Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг ХНХ-ын сайд Төмөрбаатарын Аюурсайхан танилцуулна.

Т.Аюурсайхан: УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улс 1995 онд даатгуулагч бүр хөдөлмөрийн хөлс, түүнтэй

адилтгах орлогоосоо тодорхой хувь хэмжээгээр шимтгэл төлж сан бүрдүүлэх, уг сангаас төлсөн шимтгэл авч байгаа цалин хөлстэйгөө уялдаатай тэтгэвэр тэтгэмж авах агуулга бүхий нийгмийн даатгалын тогтолцоог шинээр бүрдүүлсэн нийгмийн хамгааллын салбарт хийгдсэн томоохон шинэчлэлийн нэг болсон юм.

Нийгмийн даатгалын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 31 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн хувь хэмжээг өөрчлөх, нийгмийн даатгалын удирдлагын тогтолцоо боловсронгуй болгох зэрэг тэтгэвэр авагч, даатгуулагчийн эрх ашигт нийцсэн олон арга хэмжээг хуульчлан хэрэгжүүлсэн.

Сүүлийн жилүүдэд нийгмийн даатгалын чиглэлээр авч хэрэгжүүлж буй зарим бодлого, үйл ажиллагаа болон ирээдүйд ирэх хүн амын насжилтаас хамаарч нийгмийн даатгалын сангийн зардал улам өсөж, тэтгэврийн даатгалын сангийн алдагдал нэмэгдэхээр байгаа тул нийгмийн даатгалын сангуудын санхүүгийн тогтвортой бие даасан байдлыг хангасан сангийн менежментийг хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм. Түүнчлэн Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын ЗГ-ын 2020-24 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн даатгалын тогтолцоог шинэчлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилтуудыг тусгасан нь энэхүү хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Иймд нийгмийн даатгалын харилцааг зөвхөн нийгмийн даатгалын хуулиар зохицуулах сангийн тогтвортой байдлыг бүрдүүлэх, уг хөрөнгийг эрсдэлгүй, үр өгөөжтэй удирдах даатгалын сангийн бодит хуримтлалыг эхлүүлэх зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор энэхүү хуулийн төслийг боловсруулаа.

Хуулийн төсөлд нийгмийн даатгалын тогтолцоо, зарчим, төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, нийгмийн даатгалд даатгуулах, шимтгэл төлөх нийгмийн даатгалын санг бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох харилцааг тусгасан.

Мөн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлага, мэдээллийн нэгдсэн сан, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын итгэлцүүр шимтгэлийг нөхөн төлүүлэх, буцаан олгох, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, нэрийн дансыг мөнгөжүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх, шимтгэлийн өр, хөөн хэлэлцэх хугацааг тогтоох, нийгмийн даатгалын сангийн хэтийн тооцоолол хийх, сангийн эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий мэргэжлийн хороог ажиллуулах зэрэг зохицуулалтыг тусгалаа.

Түүнчлэн нийгмийн даатгалын байгууллага ажилтнуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, үйл ажиллагаа нь ил тод, нийгмийн даатгалын тогтолцоонд итгэх олон нийтийн итгэл үнэмшлийг дээшлүүлэх зарчмыг хуулийн төсөлд тусгасан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгмийн даатгалын хамрах хүрээ өргөжих, сангийн чөлөөт үлдэгдэл хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд оруулах боломж бүрдэж, түүнд тавих хяналт сайжрах, нийгмийн даатгалын засаглал оновчтой болж ажлын

уялдаа холбоо хангагдах, даатгуулагчид тэтгэврийн даатгалын шимтгэлийн бодит хуримтлал үүсэх ажил олгогч, даатгуулагчийн чиг үүрэг ойлгомжтой тодорхой болох, нийгмийн даатгалын үйлчилгээ цахимжиж түргэн шуурхай, ил тод нээлттэй болох юм.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлтэй уялдуулан 52 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах юм. Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээд болон иргэнд нэмэлт зардал үүсэхгүй юм. Харин хуулийг 2024 оноос хэрэгжүүлнэ гэвэл даатгуулагчийн төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг мөнгөжүүлэх зориулалтаар тэтгэврийн даатгалын санд олгох улсын төсвийн татаас 291.6 тэрбум төгрөг, зарим иргэдийн шимтгэлийг улсын төсвөөс хариуцах 48.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэх тооцоолол хийлээ.

УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Хуулийн төслийг хэлэлцэж хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Анужин: Аюурсайхан сайдад баярлалаа.

Хуулийн төслийг хэлэлцэх ажлын хэсгийн гишүүдийг та бүхэндээ танилцуулъя.

Төмөрбаатарын Аюурсайхан ХНХ-ын сайд, Гомбосүрэнгийн Өнөрбаяр тус яамны ТНБД, Амарсайханы Хишигбаяр тус яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Баасангийн Батжаргал тус яамны Нийгмийн даатгалын БХЗГ-ын дарга, Цэнд-Аюушийн Ганцэцэг НДЕГ-ын бодлогын хэрэгжилт судалгааны газрын дарга, Бумбачанаагийн Даваахүү НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газрын дарга, Сүхбаатарын Орхон ХНХ-ын яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Болдбаатарын Гэрэлсайхан ХНХ-ын яамны бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Өлзийбаярын Бодьгэрэл тус яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн гэсэн ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Хуулийн төсөлтэй холбоотойгоор асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Бадарчийн Жаргалмаа гишүүнээр тасалъя. Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Маш чухал хууль орж ирж байгаа. Мөн нийгэмд маш их хүлээлттэй байгаа хууль байгаа. Энэ Монгол Улсын энэ 2сая 200 гаруй мянган хүний эрх ашиг хөндөгддөг. Ер нь тэгээд бүх л хүний эрх ашиг хөндөгдөх ийм хууль. 1994 оноос хойш 30 удаа өөрчлөлт ороод ингээд явсан хууль одоо бол шинэчилсэн найруулгаар орж ирж байгаа. Үнэхээр ингэж найруулахаас ч өөр аргагүй болсон гэдгийг бас та бид бэлхнээ мэдэж байгаа.

Тэгээд өнөөдөр үзэл баримтлалын хувьд би дэмжиж байгаа. Тэгээд цаашдаа ажлын хэсэг гараад ажиллах байх. Би бас ажлын хэсэгт нь орж ажиллая гэсэн ийм бас саналтай байгаа. Асууж тодруулах нэлээн зүйлүүд байгаа. Энэ бас яг энэ өнгөрсөн нийгмийн даатгалын энэ багц хууль яригдаж эхэлсэн цагаас хойш ард иргэдтэй уулзахад энэ шинэчилж орж ирэх найруулга дээр чинь ийм асуудлуудыг яаж зохицуулсан юм бэ гэж асууж байгаа асуулт байгаа юм шүү гэж ингэж та бүхэн бас ойлгоод үүнийг иргэд сонсох учраас бас яг ямар зохицуулалтууд байгаа суусан юм бэ гэдгийг нь бас нэлээн сайн дэлгэрэнгүй тайлбарлаад өгөөрэй гэж хүсье.

1 дүгээрт, энэ нөгөө хувийн нэмэлт тэтгэврийн асуудал. Энэ дээр нөгөө өвлөх асуудал, тэтгэврийн насандаа хүрээд өөрсдөө захиран зарцуулах гэдэг ийм асуудлууд бас яаж сууж байгаа вэ гэдэг дээр 1 дүгээрт.

2 дугаарт, 5 жилийг 7 жил болгосон энэ зохицуулалтыг буруу юм гэдгийг бас олон гишүүд ярьж байгаа. Иргэд ярьж байгаа. Чинзориг сайдаар ахлуулсан ажлын хэсэг гараад үүнийг эргээд 5 жил болгох нь зүйтэй гэсэн ийм дүгнэлтийг бас гаргаж байсан. Тэгэхээр энэ нь яаж орж ирж байгаа вэ?

Нөгөө талдаа 5, 7 жил болгосны шалтгаан ердөө энэ тэтгэвэр шударга бус оногдоод байгаад л юм байна лээ шүү дээ. Нэг нь юу гэдэг юм 40 жил буюу 480 сар тасралтгүй нийгмийн даатгал төлж байгаад тэтгэвэрт гарахад 600-г авдаг. Нэг нь сүүлийн 5 жил буюу жаран сар нийгмийн даатгал ахиу төлөөд тэр 40 жил ажилласан хүнээс 3 дахин илүү сая дөрөв, таван зуун мянган төгрөгийн тэтгэвэр аваад байгаа гээд л зогсоох гэж үүнийг оруулсан юм байна лээ. Тэгэхээр энэ зохицуулалтыг алийг нь ч хохироохгүйгээр тэр шударга зарчим барихын тулд яаж байгаа юм.

Дээрээс нь энэ 2, 3 жилийн хугацаанд 7-5 жилээр тогтоолгосон хүмүүсийн хохирлын асуудлыг ер нь яаж харж байгаа юм бэ.

3 дугаарт, тэр үйлдвэрлэлийн осол буюу манайхны ярьдаг группийн асуудал байгаа. Ямар шинэ зохицуулалтууд орж байгаа юм бэ? Энэ дээр тэр гар хуруугүй болсон хүмүүсийг тэгээд хуруу гар нь ургахгүй хүмүүсийг жил болгон 2 жил тутам тэр ингээд л байн байн магадлалаар оруулаад л байдаг. Оюуны хомсдолтой хүмүүсийг бас байн байн оруулаад л байдаг. Маш богинохон хугацаанд. Тэгээд л зайлуул, эд нарыг чинь яг л нэг эцэг эх нь л авч ирдэг юм шүү дээ, энэ оюуны хомсдолтой хүмүүсийг, гэр орноосоо хөдөө сумаас багаас тийм энэ үүнийг бас нэг цахим болгох ийм бас нэг тийм хүнээ бодсон зохицуулалт бас яг энэ ялангуяа энэ групп буюу манайхны тэр мэргэжлийн шалтгаалах юун дээр бас хэрэгтэй байдаг юм. Тийм модон биш.

Дараагийнх нь энэ нэг ер нь нийгмийн даатгалын тогтолцоог гажуудуулахад бас нэг айхтар юм бол энэ нийгмийн даатгалын хөрөнгийн эх үүсвэрийг арилжааны банканд байршуулж байгаа юм. Өнөөдөр Капитал банкнаас 120 тэрбум төгрөгийнхөө бараг 80-аад тэрбумыг нь авч чадаагүй л байгаа байх. Тэгэхээр энэ Монголбанкны системийн нөлөө бүхий банкийг шалгаруулах гэдэг энэ нэг ужгирсан асуудлыг энэ хууль, эрх зүйн шинэ зохицуулалт дээр яаж тусгаж оруулж ирж байгаа вэ? Энэ чинь хүүгийн асуудал чинь бас энэ нийгмийн даатгалын сангийн орлогын бас нэг эх үүсвэр. Тэгээд эх үүсвэрийг банкаа сонгохдоо нөгөө л зарчмаараа явах гэж байна уу. Арай өөр зарчим руу оруулж ирж байна уу? Хэдхэн хүн үүнийг мэдээд байна уу. Эсвэл тэр үндэсний зөвлөлөөрөө шийдээд байна уу, сайд шийдээд байна уу. Эндээс болоод хохироод байгаа асуудлууд яаж орж байгаа юм бэ гэсэн ийм нэг үндсэн 4 асуултыг би та бүхнээс асууя. Тэгээд энэ дээр та бүхэн маань тодорхой хариулаад өгнө үү.

П.Анужин: Хариулт авахын өмнө би бас гишүүддээ нэг зүйлийг ахин тодруулж хэлье. Нийгмийн даатгалын багц хууль маань хамтдаа орж ирж байгаа хэдий ч хэлэлцэгдэх нь асуулт асуух нь бүгд тус тусдаа явж байгаа. Одоо бол болж өгвөл цаашдаа асуудал асуух гишүүд маань Нийгмийн даатгалын ерөнхий хуультайгаа холбогдуулж асуух хэрэгтэй. Тус тусдаа хэлэлцэгдэх учраас. Гэхдээ сая Идэрбат гишүүн асуулт асуусан учраас Идэрбат гишүүний асуусан 4 асуултад

тодорхой хариулаад дараагийн асуулт асуух гишүүд эхлээд ерөнхий хуультайгаа холбогдуулж хууль тус бүрээр асуулт үг явж байгаа учраас тийм ээ.

Аюурсайхан сайд хариулъя.

Т.Аюурсайхан: Энэ хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг бид нар үүний дараа бас дахиад хэлэлцэх эсэхийг нь шийднэ. Энэ нийгмийн даатгалын тогтолцоо үндсэндээ олон давхаргат тогтолцоо руу шилжүүлэх ийм бодлогын шинэчлэлийг эрх зүйн үндсийг нь тавьж байгаа. Тэгээд тэтгэврийн тогтолцоо 3 давхаргатай.

1 дүгээрт, халамжийн сангаас авах тэтгэвэр.

2 дугаарт, нийгмийн даатгалын сангаас авах тэтгэвэр.

3 дугаарт, энэ хувийн нэмэлт тэтгэврээ гэж шинэ энэ зохицуулалтыг хийж өгсөн байгаа.

Энэ шаардлага үндэслэл нь мэдээж байгаа Маш олон хүмүүс хөдөлмөр эрхлэгчид тэтгэврээ нэмэлт эх үүсвэрээс бүрдүүлэхийн тулд энэ эрх зүйн орчин нь байдаггүйн улмаас энэ боломжоос хомс байдаг бол энэ зохицуулалтыг хийсэн байгаа.

Тэтгэвэр тооцохдоо ажилласан жилийн дунджийг 7 жилээр болгож тооцож байгаа. 2019 оноос эхлээд 6, 7 жил гээд үе шаттайгаар явсан байгаа. Энд нэлээн олон ахмадууд маань бас тэтгэврээ тодорхой хэмжээнд бага тооцуулсан гэдэг гомдол саналууд маш их ирсэн. ЗГ дээр мөн ХНХ-ын яам дээр. Үүнийг нь бид хуучин зохицуулалтаараа дунджийг ЗГ-аас 5 жилээрээ тооцоод явах нь зүйтэй юм байна. 7-оор тооцох юм бол энэ тэтгэвэр авч байгаа ахмадуудад бас нөлөөлж байна гэдэг нөлөөллүүдийг нь гаргасан. Хууль батлагдах юм бол 5 жилээрээ бодогдоно. Үүнээс өмнө 2019-2020 онд 6, 7 жил болж тэтгэврээ тогтоолгосон нийт 48000 орчим ахмадуудын эдгээрийн тэтгэврийг нь мөн нөхөж олгох энэ дүн 60.4 орчим тэрбум төгрөг байх юм. Үүнийг бас шийдэх тооцооллыг нь хийсэн байгаа. зөвхөн энэ жил 23 он гэхэд хэрвээ 7 жилийг 5 жил болгох юм бол нэг 20 орчим тэрбум төгрөг нэмж шаардагдах болох юм. Үүнийг бид улсын төсвөөс мөн нийгмийн даатгалын сангийн менежментийг сайжруулж, өр авлагыг барагдуулах энэ арга хэмжээний хүрээнд шийдэх боломжтой гэж тооцоолсон.

Сая бас гишүүн хэллээ. Энэ сангийн үлдэгдлийг нь чөлөөт үлдэгдлийг менежмент хийх хариуцлагатай, хяналттай энэ тогтолцоо шаардлагатай. Энэ бол яах аргагүй мөн. Үнэн. Энэ чиглэлээр хуулийн төсөл 1 дүгээрт, ЗГ-ын үнэт цаас 2 дугаарт, төв банкны үнэт цаас, 3 дугаарт, төрийн санд, 4 дүгээрт системийн ач холбогдол бүхий банканд байршуулах ийм боломжуудыг зааж өгсөн байгаа. Үүнийг нь зөвхөн Төрөөс Үндэсний зөвлөл, агентлагаас хянахгүй үүнийг нь мөн олон нийтийн мэргэжлийн хөрөнгө оруулалтын энэ байгууллагуудтай хамтарч хянаж үүнийг нь байршуулж үр ашгийг нь хангаж өсгөж арвижуулах, эрсдэлээс хамгаалах энэ ажлуудыг хийх юм гэдгийг танд хэлье.

Үйлдвэрлэлийн осолд орсон хүмүүстэй холбогдуулаад манай ажлын хэсгээс нэмээд хариулъя даа.

П.Анужин: 1 номерын микрофоныг нээж өгье. Батжаргал дарга хариулна.

Идэрбат гишүүний асуултад хариулъя. ХНХ-ын яам Батжаргал.

Групп тогтоолт буюу хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэврийг тогтоох энэ эмнэлэг хөдөлмөрийн магадлал комиссын үйл ажиллагааг бүрэн цахимжуулахаар хуулийн төсөлд тусгасан. Энэ ажлын хүрээндээ бид нар эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн сантай энэ ажлаа бас сайн уялдуулах шаардлагатай болж байгаа. Тэгээд энэ зохицуулалт бол нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл дээр цахим мэдээллийн сан байна гэсэн ийм том агуулгыг тусгаад явж байгаа. Үүнийг бид нар нэг ковидын үед нэг туршиж үзсэн. Бас хүнийг ирүүлэхгүйгээр сунгах боломж нь бас байж болохоор юм байна лээ. Тэгээд үүнийгээ бид нар улам төгөлдөржүүлнэ ээ гэсэн ийм хүлээлттэй байна. Хуулиа батлагдахаар. Баярлалаа.

П.Анужин: Идэрбат гишүүн хариулт хангалттай юу. Тодруулах зүйл байна уу? Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Ерөнхий хуультай холбоотой яах вэ, нөгөө нийгмийн даатгалын тогтолцоо дээр сая өнгөрсөн онд нөгөө тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэхдээ яг тухайн үед Чинзориг нарын гишүүдийн яриад байсан бүгдийг нь ингээд автоматаар нэмэгдүүлчихээр тэр хүмүүсийн залуу насанд ажиллаж байсан тэр хөдөлмөрийн үнэлэмжүүд чинь бас тодорхой хэмжээнд хөндөгдөнө өө гэж ингэж яригдаж байсан. Тухайн үед юу гэж хариулж байсан гэхээр нийгмийн даатгалын багц хууль ороод ирэхээр энэ зөрүү юмнуудыг нь бас гаргаад ирнэ. Тухайн үед ажиллаж байсан ажлынх нь юу гэдэг юм, албан тушаал гэдэг юм уу, үүрэг хариуцлагатай нь уялдуулаад энэ зохицуулалтууд орж ирэхээр тэтгэврийн тогтолцоо өшөө шударга болно оо гэдэг ийм тайлбарыг тухайн үед өгч байсан. Тэгэхээр энэ нийгмийн даатгалын шинэ хууль дээр яг тэр бүгд 500 болчхоод байгаа, гэтэл дотор нь ангилбал янз янзын ангиллууд орох ёстой байсан тэр зохицуулалт энэ хууль дээр яг яаж туссан байгаа вэ гэдэг дээр бас нэг тодруулга авчихъя.

П.Анужин: Энэ нийгэмд асар их хүлээлт энэ уг хуулийг дагалдуулаад нийгэмд маш их хүлээлттэй байгаа тэтгэврийн зөрүүгийн асуудлыг сая Идэрбат гишүүн асууж байна. Тэгэхээр энэ дээр маш тодорхой хариултыг сайд хариулъя.

Т.Аюурсайхан: Бид нар тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийг хийхээр зорьж байгаа. Энэ хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоо руу шилжих эрх зүйн үндсийг нь тавьж байгаа. Одоо бол хуваарилалтын тогтолцоо. Тэгээд нэрийн данс бол хийсвэр бичилттэй. Бид нар нэрийн дансыг мөнгөжүүлж эхэлнэ. Хуулийн төсөл батлагдах юм бол. Ингээд цаашдаа хагас хуримтлалын тогтолцоо ингээд 2044 оноос бүрэн хуримтлалын тогтолцоондоо шилжчих юм бол хүн шударга ёсны зарчмын дагуу хэдэн жил ажиллаж хэчнээн төгрөг нэрийн дансандаа хуримтлуулсан тэрнийхээ дагуу тэтгэвэр нь тогтоогдоод явна. Одоо тэрнээс өмнө яаж байна гэхээр тодорхой. Хуулийн нэг давуу тал нь жил болгон тэтгэврээ нэмэгдүүлэх итгэлцүүрээ жил болгон баталснаар энэ цаашид зөрүү үүсгэхгүй байх нөхцөлийг нь бүрдүүлнэ.

2 дугаарт, жил болгон инфляцын түвшинтэй уялдуулж тэтгэврийг нэмэгдүүлдэг болох эрх зүйн орчныг нь тавьж байгаа юм. Өмнө нь үүссэн зөрүүнүүдийг эхлээд арилгаж байж дараа нь энэ хуулийнхаа хэрэгжилтийг явахгүй бол энэ цаашаа гажуудаад явна. Тийм учраас бид нар … /минут дуусав/

П.Анужин: Аюурсайхан сайдад нэмэлт 1 минут өгч асуултаа гүйцээе. Хариултаа гүйцээе.

Т.Аюурсайхан: Баярлалаа. Тэгэхээр эхлээд үүссэн саяын хэлж байгаа сүүлийн тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүллээ шүү дээ. Бүрэн тэтгэвэр 500 мянга бүрэн бус хувь тэнцүүлсэн тэтгэвэр 400 мянга гээд. Ингэхэд бас тодорхой хэмжээний гажуудал үүсээд дунд түвшний тэтгэвэр авч байсан хүмүүс бага, доод тэтгэврийн доод хэмжээний тэтгэвэр авдаг хүмүүс болсон байгаа. Энд багш нар, эмч нар ингээд дунд түвшний удирдах албан тушаал хашиж байсан зөндөө хүмүүсийн ийм асуудлууд байгаа. Тийм учраас хамгийн түрүүнд энэ хүмүүсийнхээ энэ тэтгэврийн зүй бус зөрөө үүссэн энэ асуудлуудыг эхлээд эмхэлж цэгцэлж байгаад тэгж байгаад дараа нь энэ тэтгэврийг жил болгон нэмэгдүүлдэг итгэлцүүрээ шинэчилдэг энэ асуудлуудыг нэг мөр болгох нь зүйтэй гэж бодож байгаа.

Мэдээж ЗГ-аас энэ төсвийн нөөц боломжтойгоо уялдуулаад эхлээд энэ тэтгэврийн зөрүүгээ засаж байж дараа нь бусад хуулийнхаа процессыг явуулна гэж ингэж бодож байгаа.

П.Анужин: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

М.Оюунчимэг: УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор ЗГ-ын 20-24 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг батлахад нийгмийн даатгалдаа шинэчлэл хийж олон давхаргат тогтолцоонд орох, иргэдээ хуримтлал үүсгэх, өвлүүлэх гээд өөрөөр хэлбэл энэ нийгмийн даатгал маань төлж байгаа хүн дараа нь амьдралын баталгаа нь болж өгөх асуудлыг бид бүрэн нь шийднэ ээ гэж амлаж байсан. Нийгмийн бодлогын байнгын хороо тухайн үеийн ХНХ-ын сайд нарт энэ хуулиа хурдан оруулж ирж яаралтай хэлэлцүүлээч ээ гэж маш их шахаж шаардаж байсан. Тэгээд энэ удаад Аюурсайхан дарга сайд ингээд ХНХ-ынхан маань үүнийг ингээд оруулаад ирлээ. Өмнө нь Ариунзаяа сайдын үед оруулж ирэхэд ЗГ-ын 2 яам зөрчилдөөнтэй байсан. Сангийн яам, ХНХ-ын яам хоёрын зөрчилдөөнөөс болоод орж ирсэн багц хууль маань буцсан. Тийм ээ. Хамгийн гол шалтгаан нь Сангийн яам санхүүжилттэй холбоотой асуудал дээр байр суурь нэгдээгүй. Ялангуяа 2 хувь хувь хүний нэг хувь, ажил олгогчийн нэг ху буюу 2 хувийг төсөв, сангаас энэ хувь хуримтлал маягаар нөөц санд байршуулна гэдэг нь боломжгүй. Энэ бол төсвөө төрийн татаад унагах нь, улсын төсвийг татаж унагана. Ийм байдалд хүрэх болоогүй гэдгээ шалтгаанаар буцаж байсан. Том ажлын хэсэг дээр би бас ахалж байсан л даа. Тэгэхээр өнөөдөр Сангийн яамнаас энд ажлын хэсэгт хүн орж ирсэн байгаа юу? Сангийн яамны байр суурийг сонсмоор байна. Энэ дээр засгийн Сангийн сайдын өгсөн хариулт дээр хэлэлцэх, өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна гээд хэлсэн байна л даа. Тэгэхээр Аюурсайхан сайд аа, Жавхлан сайдын хувьд зүгээр Сангийн яамны хувьд энэ хууль бодит амьдрал дээр хэрэгжихэд санхүүжилтийн хувьд асуудал тулгарахгүй. Яг тэр сая энэ хуулийн төсөлд тусгагдаад ороод ирж байгаа тэр 2 хувь нөөц сан бий болгох энэ өөрөө хэрэгжих энэ тэр дээр Сангийн яамтайгаа санал нэгдсэн үү? Ер нь энэ хууль хэлэлцэх үед, Сангийн яамнаас зайлшгүй ажлын хэсэгт хүн байх ёстой шүү гэдгийг хэлье. Тэгээд энэ асуултад хариулт авчхаад тодотгоё гэж бодож байна.

Ерөнхийдөө энэ нийгмийн даатгалын багц хуулийг оруулж ирээд хэлэлцэхийг 100 хувь дэмжиж байна.

П.Анужин: Аюурсайхан сайд хариулъя.

Т.Аюурсайхан: Оюунчимэг гишүүн маш чухал асуудал хэллээ. Ер нь гол асуудал нь л даа. Бид нар том зорилго хуулийн том реформ тавьж болно. Хамгийн гол нь улсын нөгөө төсвийн нөөц боломж нь хаанаа байна. Тийм учраас бид нар Сангийн яам дээрээ энэ талаар тооцоон дээрээ бас нэлээн суусан. Сангийн яам тэтгэврийн реформын энэ шинэчлэлийг дэмжиж байгаа. Энэ бол цаашдаа олон жил энэ хуучин шигээ тогтолцоогоороо хуваарилалтын тогтолцоо руу явах боломжгүй. Тийм учраас нэрийн данс ингэж хийсвэр бичилтэй явах боломжгүй. Одоо 2029 оноос эхлээд 1979 онд төрсөн хүмүүс энэ нөгөө хуримтлалынхаа зарчмаар тэтгэврээ тогтоолгоод эхлэхэд бэлтгэл ажил нь хаана байгаа юм. Тийм учраас бид нар ямар ч л байсан улс төсвөөсөө анхаарал тавиад тодорхой хэмжээнд бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжихэд цаг хугацаа байгаа ч гэсэн хагас хуримтлалын тогтолцоо нь руугаа бас үе шаттайгаар явъя. Тэгэхийн тулд даатгуулагч нэг хувь, ажил олгогч нэг хувь, одоо төлж байгаа хэмжээний дотор шүү дээ. Үүнийгээ нөөцдөө бүрдүүлье ээ. Үүнийхээ зөрүүг нь улсын төсвөөс гаргая. Зөвхөн үүгээр тогтохгүйгээр байгалийн баялгаас одоо тодорхой хэмжээний хөрөнгийг нөөц санд хуримтлалаар үүсгэе. Иргэдийнхээ тэтгэврийн санд. Түүгээрээ дамжуулаад орон сууц, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээгээ авдаг түүнийгээ бас өвлүүлдэг боломжтой болгоё оо гэдэг энэ зарчим дээр нь санал нийлсэн.

Энэ одоогийн хүчин төгөлдөр хууль, эрх зүйн хүрээнд ганцхан тэр байгалийн баялгаас авах зохицуулалт нь Ирээдүйн өв сангийн тухай хууль дээр байна. Баялгийн сангийн хуулийг бид нар одоогоор хэлэлцээгүй байна. Хуримтлалын сангийн хуулийг хэлэлцээгүй байна. Тэгэхээр одоогийн байгаа Ирээдүйн өв сангийн хууль дээрээ 2029 оноос эхлээд Ирээдүйн өв сангаас тодорхой хэмжээнд улсын төсөвт хувь нэмэр оруулна гэдэг заалт байгаа. Яг хэд нь бол тодорхойгүй. Тэгэхээр тэр улсын төсөвт оруулж байгаа мөнгөнийх нь ерөөсөө 30 хувийг нь энэ тэтгэврийнхээ нөөц санд оруулчихъя гэдэг төсөл байсан юм. Тэгээд яагаад 30 хувь гэж байгаа гэх юм бол нийт ард иргэдийн 30 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа учраас байгалийн нөөц баялгаас Ирээдүйн өв санд зориулж цаашдаа тэтгэвэрт гаргах хүмүүст зориулж мөн нийт төсөвт оруулж байгаа мөнгөний 30 хувийг нь оруулъя гэдэг концепцыг гаргасан. Гэхдээ 30 дээрээ эргэж харъя. Үүнийгээ ЗГ тогтоодоггүй ээ, хэд ч байж болно. 30-аас бага уу, 30 уу. Тийм учраас яг хатуу 30 гэдэг биш байя. Зарчим нь бол Ирээдүйн өв сангаас байя. Гэхдээ ирээдүйн өв сан одоогийн цорын ганц бидний баримжаалж байгаа эрх зүйн орчин байгаа юм. Гэхдээ бид нар энэ хуулиараа бүх энэ нөөц санг бүрдүүлэх хуримтлалын сан бий болгох орчныг нь суурийг нь бий болгочихсон учраас цаашдаа одоо Баялгийн сангийн хууль орж ирээд хуримтлалын сангийн хууль орж ирээд Ирээдүйн өв санг дагаад энэ дээр хэрвээ засвар өөрчлөлт хийх юм бол эргүүлээд энэ дээрээ бас тохируулга хийх ийм суурийг нь бас тавиад өгсөн юм.

Тэгэхээр Сангийн яамны зүгээс бас тодорхой төсвөө ачаалал дээр бид нар бас тооцоо нийлээд яг өргөн барьсан хэмжээнд зөвшөөрсөн. Төслийн хэмжээнд Сангийн яамнаас 16 санал ирүүлсэн. Ихэвчлэн төсвийн тооцоололтой холбогдуулаад. Бид нар энэ саналуудыг ерөнхийдөө бүгд дээр нь Сангийн яамтай санал нийлээд бас хүлээж аваад ингээд өргөн мэдүүлсэн байгаа гэж танд хэлье.

П.Анужин: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулъя.

М.Оюунчимэг: Хууль гаргах мэдээж нэг хэрэг. Бид нар яаралтай горимоор ч гэсэн баталж болно. Хамгийн гол нь нөгөө санхүүжилтээсээ болоод хууль хэрэгжихгүй. Энэ нь өөрөө маш том алдаа болдог. Тийм учраас 16 чиглэлээр

Сангийн яамнаас саналууд өгсөн гэж байна. Мэдээж Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах байх. Бид сая хүүхдийн мөнгөн дээр л гэхэд 800 гаруй тэрбум төгрөгийг олох гэж юу болов? Бүх хөрөнгө оруулалтуудыг зогсоож байна. Одоо эдийн засаг энэ 23 он, 24 онд мэдээж тодорхой хэмжээгээр өснө. Гэхдээ бид нарын тооцоолж байгааг бас амаргүй байгаа шүү дээ. Гадаад зах зээлийн нөхцөл байдал хэдийгээр ингээд урд хил боомт нээгдэж байгаа ч гэсэн. Тэгэхээр энэ мөнгө олох асуудал байгаа. Бид нар энэ 2 хувиа ингээд нөөцөө бүрдүүлээд яачих вэ. Мэдээж 29 он гэхэд энэ хуримтлал руу үүсэх гээд нэлээд урт хугацаа заасан байна л даа. Тэгэхдээ хуваарилалт, хуримтлал руу гэж байгаа. Бид нар Өнөрбаяр дарга бас мэдэж байгаа. ХБНГУ хамгийн сайн жишиг байгаа тэтгэврийн тогтолцоо энэ тэр жишээлбэл. Гэхдээ ямар ч дэлхийн хямралын үед хамгийн сайн тогтолцоо нь өөрөө хуваарилалтын тогтолцоо байсан … /минут дуусав/

П.Анужин: Санал уу тийм ээ. Батсүхийн Саранчимэг гишүүн асуулт асууя.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр манай Монгол Улсын нийгмийн хамгааллын тогтолцоо бол нийгмийн даатгал, нийгмийн халамж гэсэн энэ 2 үндсэн хэсгээс бүрдэж байгаа. Тэгээд тэрний нэг гол бүрэлдэхүүн хэсэг болох энэ нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг бид нар бас хэлэлцэж байна. Хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа юм. Тэгэхдээ ер нь энэ том хуулийг бид нарт яг 1 цаг тулгаад өчигдөр л гээд л ингээд өгч байгаа учраас ер нь цаашдаа бас нийгмийн хамгааллын яам ч гэсэн орж ирж байгаа асуудлууд дээрээ бас өмнө нь мэдээллүүдээ эрт өгч байхыг хүсэж байна.

Энэ нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төслийн талаар бас тодруулах зүйл байгаа. Тэгэхээр өмнөх төслөө энэ хууль татаж аваад өргөн мэдүүлсэн өнөөдрийн энэ нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд өргөн мэдүүлсэн гол шинэчлэлүүд нь юу вэ? Энэ хуулийн төсөл боловсруулахдаа мэргэжлийн байгууллага, эрдэмтдийн одоо эрдэмтдээс санал авсан байгаа юу гэсэн нэг ийм асуулт байна.

Нөгөө талаар энэ хуулийн төслөөр энэ мэдээж энэ санхүүгийн тогтвортой, бие даасан, найдвартай байдлыг хангасан байх зарчмыг баримтлан сангийн зөв менежментийг хэрэгжүүлэхээр тусгасан гэж хуулийн төсөлд хэлсэн байна. Тэгэхээр манай өнөөгийн энэ нийгмийн даатгалын зарим хүндрэл, алдаа дутагдал яах аргагүй энэ арга менежментийн алдаанаас болсон гэдгийг бас судлаачид бас хэлсэн байгаа. Тэгэхээр энэ төсөлд ямар чухал менежментийн шийдлүүдийг оруулж ирсэн бэ?

Нөгөөтээгүүр энэ ерөнхий хуулийн төсөлд НДШ, алданги, торгуулийг цуглуулах, төвлөрүүлэх үйл ажиллагааг татварын алба гүйцэтгэхээр тусгасан байсан. Энэ төслөөр нийгмийн даатгалын байгууллага өөрөө гүйцэтгэхээр оруулж ирж байгаа юу. Энэ дээр нэг тодруулга өгөөч. Баярлалаа.

П.Анужин: Ажлын хэсэг хариулъя. Өнөрбаяр дарга 2 номерын микрофонд хариулт өгье.

Г.Өнөрбаяр: Өмнө нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль бас өргөн баригдаад 3 зарчмын зөрүүтэй санал дээр бас эргэж ярихаар болсон. 1 дүгээрт нь, энэ хуримтлалын сантай бас Нийгмийн даатгалын багц хуулийг уялдуулах гэдэг ийм асуудал яригдсан. Бид нар энэ одоо өргөн барьсан хууль дээрээ тэтгэврийн

нөөц сан байгуулаад хуримтлалын нэгдсэн сантай уялдуулах, цаашид нийгмийн даатгалын өөрөөр хэлбэл хүмүүсийн төлсөн шимтгэл мөнгөжсөн тохиолдолд хуримтлалын сантай уялдах энэ зохицуулалтуудыг бас хуулийн төсөл дээр тусгаад оруулж ирсэн.

2 дахь яригдсан асуудал бол өмнөх хуулийн төсөл дээр хүмүүсийн тэтгэвэр бодолтыг бас бууруулсан байна гэдэг ийм асуудал яригдсан. Үүнийг бид нар засаад харин ч нэмэгдүүлж оруулж ирсэн. Одоо өөрөөр хэлбэл улсад 20 жил ажиллахад тухайн хүний тэтгэврийг 45 хувиар буюу эхний 20 жилд нь 2,25-аар, 20-оос илүү жилд нь 1,5-аар боддог ийм тогтолцоо байгаа. Цаашид бид нар өөрөөр хэлбэл 29 оноос хойш 20-оос илүү жил ажилласан бүх жилүүдэд нь 2 хувиар бодохоор ийм бодолтой ийм томьёоллуудыг оруулж ирсэн. Энэ нь юутай холбоотой вэ гэхээр насжилттай холбоотой. Хүмүүсийг илүү урт удаан хугацаанд ажил хөдөлмөр эрхлэх энэ бодлогуудтай уялдаатай. Үүний үр дүнд хүмүүсийн тэтгэвэр буурахгүй. Харин олон жил ажилласан хүмүүсийн тэтгэвэр өндөр тогтоогдох ийм сайн зохицуулалтыг бид нар бас оруулж ирсэн гэдгийг хэлэх ёстой.

Дараагийнх нь Саранчимэг гишүүн бас нийгмийн даатгалын сангийн засаглал, менежменттэй холбоотой асуудлыг бас хөндөж ярилаа. Энэ бид нарын энэ өргөн барьсан хуулийн төсөл дээр нийгмийн даатгалын засаглалыг аль болохоор олон улсын жишигт уялдуулах ийм бодлогыг бас дэвшүүлж оруулж ирсэн. НДЕГ-ын дэргэд ялангуяа энэ мэргэжлийн хороодыг ажиллах ийм томьёоллуудыг оруулж ирсэн. Энэ эрсдэлийн удирдлага, санхүү, хөрөнгө оруулалтын акторын гээд бүх мэргэжлийн хороод бас ажиллана. Энд мэргэжлийн нийгмийн даатгалаар мэргэшсэн хүмүүс ажиллаад нийгмийн даатгалын сангийн өнөөгийн энэ байгаа байдал, эрсдэлүүд, ирээдүйд гарах хүчин зүйлсүүд бүгдэд нь ингээд үнэлэлт дүгнэлт өгөөд энэ бүх мэдээллүүд бүх даатгуулагчдад бүх ажил олгогчдод бас нээлттэй байхаар энэ хуулийн төсөл дээр оруулж ирсэн гэдгийг хэлье.

Өмнө нь бид нар нийгмийн даатгалын багц хууль дээр нийгмийн даатгалын орлого талыг бас татвартай нэгтгэвэл яасан юм бэ гэдэг ийм томьёололтой байсан. Одоо бол бид нар нийгмийн даатгалын байгууллага өөрөө энэ орлогоо төвлөрүүлэхээр ийм зохицуулалттайгаар өргөн барьсан гэдгийг хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Анужин: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууя.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Дэмжиж байгаа. Энэ чухал хуулиа хэлэлцэхээр төсөл гарч ирж байгаа. Энэ дотор би бас нэг энэ эрүүл мэндийн магадлан итгэмжлэл өгдөг нэг ёсондоо групп тогтоох асуудал дээр хэр дэвшил гаргахаар энэ төсөлдөө оруулж өгсөн бэ? Эрүүл мэндийн магадлалын зөвлөл гээд энэ яаж байгуулагдах талаар та бүхэн энд оруулсан байна. Ер нь гадаад орнуудад хийдэг туршлага ямар байна. Энэ тал дээр тодруулж мэдээлэл өгнө үү?

Ер нь энэ өвчний групп тогтоох, хөдөлмөр алдалтыг тогтоох энэ ер нь цадигаа алдсан, заримдаа бүр зарим газар үүнийг бүр хоморголон оруулж, хоморголон оруулж, бүр заримдаа бүр улс төрийнхөө хэрэгсэл энэ тэр болгож байгаа явдал байгаад байгаа шүү. Тийм учраас бид хэрэгтэй, үнэхээр хөдөлмөрөө алдалттай тэр өвчин зовлонтой, өөрөө ажил эрхэлж чадахгүй болсон улсууддаа хүргэж чадахгүй зүгээр нэг дэл сул улсуудад хамаг мөнгөө барж байгаа явдлууд байгаа. Тэгэхээр энэ дээр бид илүү яаж тунгалаг болгох вэ? Үүнийг яаж

сайжруулах вэ. Энэ тал дээр хуульдаа та бүхэн яаж тусгасан бэ? Энэ талаар нэмэлт мэдээлэл өгөхгүй байна.

П.Анужин: Чинбүрэн бас гишүүний асуусан асуулт өнөөдрийн хэлэлцэх асуудлын 4, 5 дугаарт байгаа асуудал. Гэхдээ энэ өнөөдрийн бас багц хуульд байгаа асуудал учраас уг асуултад бас хариулъя. Дараа нь бид нар ахиад энэ тал дээр бас бусад нь энэ хууль дээр ярилцана шүү дээ.

Өнөрбаяр дарга хариулах уу? 1 номерын микрофонд Батжаргал дарга хариулъя.

Б.Батжаргал: Чинбүрэн гишүүний асуултад хариу хэлье. Групп тогтоолт нэлээн хэл амтай байсан. ХНХ-ын яам, холбогдох цагдаагийн байгууллага бусад байгууллагатай хамтраад сүүлийн 3 жил дараалан шалгалт хийсэн. 110000 хүн улсын хэмжээнд байсан. Одоо 7000-аар буурсан. Холбогдох арга хэмжээнүүдийг цагдаагийн байгууллага АТГ-тай хамтраад шалгаад ер нь бүх аймгуудыг шалгаж дууссан.

Хуулийн төсөл дээр яаж орж байна вэ гэхээр эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын нэршлийг өөрчлөөд, дээр нь бүрэлдэхүүнийг нь бас нэлээн олон нийтийн ийм хараат бус гишүүдийг оруулж ирэхээр бас хуулийн төсөлд тусгасан байгаа. Дээр нь бас нэг зохицуулалт нь хүнд бас ээлтэй болгоё. Яг үнэхээр өвчтэй хүмүүсийг ямар нэгэн саад бэрхшээлгүй прокуротгүй оруулъя, хууль зөрчөөд байгаа асуудал дээр хандаж тэмцье гэсэн иймэрхүү байдалтайгаар хуулийн төсөлд тусгасан байгаа. Баярлалаа.

П.Анужин: Содномын Чинзориг гишүүн байхгүй байна. Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна.

С.Одонтуяа: Баярлалаа. Тэгээд энэ чухал хууль бас орж ирж байгаа юм байна. Олон хүний хүч хөдөлмөр олон жилийн юу шингэсэн байх, хариуцлагатай орж ирсэн байх. Нэг хэдэн юм асууя. Ер нь зүгээр миний бодол ийм байдаг юм. Одоо энэ манай улсад харж байхад бид нар энэ халамжлах ёстой хүмүүс, тэтгэврээ тогтоолгочхоод авах ёстой хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст улс нэг их гар татаад байх хэрэггүй юм шиг санагддаг юм. Яагаад гэхээр эдгээр хүмүүсийн авч байгаа мөнгө маш бага мөнгө байдаг байхгүй юу. Бид нар яаж ч шинэчлэл хийгээд энэ хүмүүс зүгээр нэг амьдралын нэг дөнгөж нэг залгуулах төдий. Монголчууд нөгөө олуулаа хүүхдүүдтэйгээ байдаг тулдаа л ер нь ингээд нэг юмнууд нь жоохон хүрдэг. Тийм учраас энэ дээр бид нар нэлээд сайн шинэчлэл хийх ёстой. Тэрний оронд харин эсрэг энэ хэдэн тэрбумаар нь хулгайлдаг хулгайгаа л багасгачихвал улсад мөнгө байна шүү дээ.

Тэгэхээр нэг хэдэн юм асуух гэсэн юм. Энэ сая бас сайд хэллээ. Одоо бид нар чинь нөгөө энэ сангаа мөнгөө нэг мөнгөжүүлнэ гээд л их олон жил ярьсан шүү дээ. Тийм ээ, мөнгөжүүлнэ. Тэгээд манай Ганбаатар гишүүн бас байнга л яриад байсан. С.Ганбаатар. Тэгэхээр үүнийг яг яаж ямар үе шаттай хийх гэж байгаа юм бэ? Мэдээж нэг дор бүгдийг нь хийж чадахгүй байх. Тэгэхээр миний бодлоор энэ баялгийн сангаасаа юм уу, энэ уул уурхайн орлогоосоо бид нар яаж ийж байгаад л энэ тодорхой хэмжээгээр нэг мөнгөжүүлээд авчихвал энэ өөрөө их чухал байгаа юм л даа. Энэ дээр асуух гэсэн юм.

2-т, энэ зарим оронд энэ хүмүүс тэтгэврээ ингээд үе шаттайгаар авдаг. Зарим нь эсвэл нэг бөөнд нь авъя гэдэг ч юм уу ийм бас нэг сонголтууд байдаг юм. Тэгэхээр манайд тийм юм байна уу, өвлүүлэх юм байдаг юм уу. Тэгээд тэтгэврийн зээлтэй хүмүүс чинь нөгөө нас барахаар тэтгэврийн зээл нь нэг асуудал болоод байдаг шүү дээ. Бас л өвлөгдөөд. Энэ дээр яаж тусгасан юм бол? тэгээд энэ хамтын тэтгэврийн хууль гээд уг нь байсан юм. Тэр яг Монголын нөхцөлд үг нэг таарсан хууль байсан юм л даа. Яагаад гэхээр Монголчууд чинь ерөөсөө нөхөр нь яваад гол ажлаа хийгээд эхнэр нь маш олон хүүхэд өсгөж байна шүү дээ. Бусад оронд нэг 2 л хүүхэдтэй. Манайд 4 хүүхэд, 5 хүүхэд, 6 хүүхэд өсгөж байгаа. Ээж хүн бараг яваад ажил хийгээд тэтгэвэр нь өндөр тогтоолгоно гэж бараг байдаггүй байхгүй юу. Яг л хамтын амьдралаар байдаг. Тэгэхээр нөгөө нөхөр нь ингээд өндөр цалинтай, өндөр ч байх вэ дээ. Цалин авч байгаа нь нас бардаг. Нөгөө эхнэр бүр шууд ядуурлын хэмжээ рүү оччихдог. Хамгийн бага тэтгэвэртэй. Тэгэхээр уг нь энэ их зүгээр хууль байсан юм. Тэгэхээр нэгэнтээ ингээд энэ байхгүй болчихсон учраас эмэгтэйчүүд дээр нэг ийм асуудал гараад байгаа юм. Тэгэхээр өрх толгойлсон ээжүүдэд ямар нэгэн энэ багц хуулиар юмнууд орж ирэх юм уу. Энэ чинь олон жил хүүхдээ харна гэдэг чинь бас улс орны байдалд хувь нэмрээ оруулж байна л гэсэн үг байгаа юм. Тэгэхээр үүнийг нэг эдгээр асуултуудад нэг сайн хариулаад өгөхгүй юу.

Монголчууд чинь нэг их тийм айхтар их өмч хөрөнгө байдаггүй болохоор тэгээд л нэг тэтгэвэр нь л яг амь зогоох хэрэгсэл болчхоод байгаа юм л даа. Тэгээд энэ нөхөн төлөх асуудал дээр бас ямар зүйл орж ирж байгаа юм? Яагаад гэхээр хуучин тэр Эрдэнэ гишүүний нөгөө баталж байсан хууль нөгөө 90 оны яг шилжилтийн үеийнх байсан болохоор яг тэр үедээ их зохисон байхгүй юу. Яг одоо ингээд хүмүүс нэг хэсэг нэг нийгмээс нөгөө рүү нийгэм рүү шилжээд, одоо ингээд хүмүүс боломж нь байхад нийгмийн даатгалаа төлөхгүй байж байгаад ингээд нөхөөд төлдөг бас зарим олон жил төрсөн хүмүүс бас дургүйцээд байдаг юм. Тэгэхээр энэ дээр нөхөн төлөх дээр тийм ялгавар гарч ирж байгаа юу гэдэг асуулт.

П.Анужин: 1 номерын микрофонд хариулт өгье. Батжаргал дарга хариулах уу? Өнөрбаяр дарга 2 номерын микрофонд хариулт өгье.

Г.Өнөрбаяр: Одонтуяа гишүүн их олон чухал асуулт асуулаа. Би тэгээд эхнээс нь хариулаад явъя. Энэ мөнгөжүүлэхтэй холбоотой асуудлыг өмнө нь бас их олон удаа яригдсан. Бид нар энэ хуулийн төсөл дээрээ мөнгөжүүлэх асуудлыг бас оруулж ирж байгаа 2 хэлбэрээр. 1 дүгээрт нь, энэ хууль хэрэгжиж эхэлснээр одоогийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэг, нэг хувийг өөрөөр хэлбэл хуримтлахаар ийм зохицуулалтыг бид нар бас оруулж ирсэн байгаа. Мөн 29 оноос эхлээд Ирээдүйн сангийн тухай хууль хэрэгжиж эхлээд энэ хуулиар өөрөөр хэлбэл улсын төсөвт тодорхой хэмжээний баялгийн хуваарилалтууд улсын төсөв рүү орох асуудал орж ирж байгаа. Үүнээс бас тодорхой хэмжээний тухайн үед нь бас энэ мөнгөжүүлэхтэй холбоотой асуудлыг бас хамтад нь оруулж ирж байгаа юм.

Одоогийн байдлаар би Байнгын хорооныхоо гишүүдэд мэдээлэл өгөхөд бол хүмүүсийн төлсөн шимтгэлтэй холбоотой 2 асуудал байгаа. 1 дүгээрт нь, бид нарын өнөөдрийн төлсөн шимтгэлийг тэтгэвэр болгоод ингээд явсан. Үүнтэй холбоотой бид нарын хамгийн сүүлийн мэдээллээр нэг 23 орчим их наяд төгрөгийн асуудал байгаа. Энэ мөнгийг бид нар бас улсын төсвөөс өгөх ёстой гэдэг нэг асуудал.

2 дугаарт нь, 95 оноос өмнө ажилласан хүмүүсийн жилүүд байгаад байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл энд байгаа хүмүүсийн бас тодорхой хугацаа нь 95 оноос өмнө бас улс хариуцаж байх үед бас оногдож байгаа. Энэ мөнгийг бас тодорхой хэмжээнд мөнгөжүүлээд энэ тэтгэврийн нөөц санд байршуулаад эргээгээд үүнийг өөрөөр хэлбэл зарцуулах энэ боломжуудыг нь нээж өгөх ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа, манай яамны хувьд бол.

Тэтгэвэр авалтын сонголтын асуудлыг бас гишүүн хөндлөө. Одоо бид нар хуваарилалтын тогтолцоотой байгаа учраас энэ маань сар болгон ингээд явдаг. Энэ хуваарилалтын тогтолцоогоор явна. Цаашдаа бид нар хагас болон бүрэн хуримтлалын тогтолцоо руу шилжвэл энэ асуудал яригдана. Харин хувийн нэмэлт тэтгэврийн хууль дээр энэ тэтгэврийг ямар хэлбэрээр авах вэ гэдгийг 3 сонголтоор бид нар хувь нэмэлт тэтгэвэр дээр оруулж өгч байгаа. Нэг удаа бөөн дүнгээр нь авч болно. Улирлаар нь бас авч болно. Эсвэл одоогийнх шиг хуваарьтай буюу насан туршид нь авахаар энэ зохицуулалтуудыг бас хийж өгнө гээд хүмүүст аль болохоор бас сонголтыг өгч байгаа гэдгийг хэлэх ёстой.

Өрх толгойлсон эмэгтэйчүүд болон эмэгтэйчүүдтэй холбоотой ямар зохицуулалтыг нэмсэн бэ гэдэг ийм асуудал хөндөгдлөө. Бид нар энэ дээр ялангуяа энэ хөгжлийн бэрхшээлтэй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг гэртээ хараад ажил хөдөлмөрөө хийж чадахгүй байгаа ийм нөхцөл байдал бас байгаа. Энэ ээжүүдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нь бас төрөөс хариуцаж төлөхөөр хуулийн төсөл дээр бас оруулж ирсэн. Энэ хуулийн хэлэлцүүлгийн хүрээнд бид нар ялангуяа энэ салбарын хүмүүс нэлээд бас хэлэлцүүлэг хийгдсэний үр дүнд яригдсан нэг асуудал нь энэ байна.

Мөн бас хамтын тэтгэвэртэй холбоотой асуудлыг бас гишүүн хөндлөө. Үүнтэй холбоотой бас тусгай зохицуулалтыг бид нар хуулийн төсөл дээр оруулж ирсэн. Хууль дээр тусгай зохицуулалт гээд эхнэр, нөхөр хоёрын хамтран гэр бүл болсон эхнэр, нөхөр хоёрын аль нэг нь нас барвал тэтгэвэр нь 20 хувиар нэмэгдэж байхаар ийм зохицуулалтыг бас хуулийн төсөл дээр оруулж ирсэн гэдгийг бас хэлье.

Нөхөн төлөлттэй холбоотой өмнө нь бас нэлээд олон яригдсан. Цаашдаа манай яам энэ нөхөн төлөлтийн хуулийг бас хэрэгжүүлэхгүй байвал яасан юм бэ гэдэг ийм байр суурьтайгаар цаашид ер нь Монгол Улс нөхөн төлөлтийн хуулийг хэрэгжүүлэхгүй гэдгийг олон нийтэд нээлттэй зарлаад явах нь Нийгмийн даатгалын сандаа ч хэрэгтэй байна, хүмүүсийн хандлагад ч бас хэрэгтэй байна. Тийм учраас бид нар энэ хууль дээр нөхөн төлөлтийг хэрэгжүүлэхгүй ээ гэсэн ийм томьёололтойгоор бас оруулж ирсэн гэдгийг хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Анужин: Та тэгээд асуулт асуух гишүүдийн нэрсийн дараалалд Чинзориг сайдын нэрийг оруулж өгөхийг хүсье.

Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууна.

Ц.Туваан: Энэ хуулийн төсөл оройтож байгаа. Бид нар бас эрт орж ирээсэй гэж ингэж бодож байсан. Тэгэхээр бас оройтсон ч гэсэн орж ирж байна. Тэгээд яах вэ энэ хуулийн ерөнхий хууль дагасан энэ хуулиудыг ингээд харахаар энэ төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого 2030-ийнхаа хүрээнд бодлогуудаа явуулж байх шиг байна. Тэгж харагдаж байна. Тэгээд тодорхой хэдэн асуултыг асууя.

Энэ хуваарилалтаас хагас хуримтлалын тогтолцоо руу шилжинэ ээ гээд байна. Яг ний нуугүй хэлэхэд бид нар хуваарилалтын тогтолцоогоор авч байгаа шимтгэлтэй харьцуулахад энэ тэтгэвэр хамаагүй өндөр тогтоогдож байгаа шүү дээ. Тэгэхээр одоо хуримтлал хагас хуримтлал руу шилжсэнээр тэтгэвэр яг яах юм нэмэгдэх үү, хэвэндээ байх уу, буурах уу. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөдхөөч.

Сая бас энэ ажлын хэсгийн хариулт дээр гараад байна. Энэ 2029 оноос хойш энэ 20-оос дээш жил ажилласан хүмүүсийн илүү жилийг 1.5 хувь байсныг 2 хувиар бодно оо гээд. Энэ энэ тэр дээр чинь ний нуугүй хэлэхэд энэ сан чинь даах уу. Яаж тооцоолсон юм, энэ 2 хувь болгоно гэдгийг. Нэг ийм асуулт байна.

Тэгээд иргэдтэй бас уулзаад явж байхад энэ нэлээн тэтгэвэртэй холбоотой маш их асуудал яригддаг. Сая ингээд бид хэд ноднингийн цагаан сараар нэг бүх бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500000 болгоод бараг тэгшитгээд ингээд өгчихсөн. Хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 400000 болоод өгсөн. Тэгээд өмнө нь арай жаахан өндөр тэтгэвэр авч байсан хүмүүс гомдолтой байгаа. Ойролцоо ирчихсэн. Тэгээд юу хэлж байна гэхээр энэ ахмадууд маань тэтгэвэр бага байна гэхээсээ илүүтэйгээр тэтгэврийн зөрүү гэдэг нэг ойлголттой байдаг. Тэтгэврийн зөрүү яагаад ингээд арилгахгүй байна. Яагаад, яг ижил хугацаанд, ижил мэргэжлээр, ижил жил ажилласан хүмүүс 2 янзын хамаагүй тэнгэр газар шиг 2 янзын тэтгэвэр аваад байна гэдэг дээр л ярьж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр яг энэ хуулийн төсөл дээр энэ тэтгэврийн зөрүү буюу энэ шударга байдлын талаар энэ шинэ хууль дээр яаж тусгасан бэ?

Дараагаар энэ итгэлцүүр ер нь хэдэн оны итгэлцүүрээр бид нар яваад байна. Бараг 10 жил болж байгаа байх даа. 10 жилийн дотор юмны үнэ хэд дахин өслөө. Валютын нь үнэ хэд дахин өслөө. Тэгэхээр энэ итгэлцүүрээ яг энэ хуульд хэдэн жил жилд нь яг барьж явдаг хуулиа мөрдөж явдаг болох уу? Энэ талаар яг энэ хуульд яг яаж тусгасан юм бэ? Тэгээд л энэ аль эрт оны итгэлцүүрээр бодоод яваад байдаг. Өнөөдөр юмны үнийн инфляц ямар байгаа билээ. Тийм ээ. Нөгөө 500 мянгын болгосон тухайн үедээ ахмадууд алга ташиж байсан хөөрхий. Одоо тэр чинь юу ч биш болчхоод байна шүү дээ. Тэгэхээр энэ инфляц юмны үнийн өсөлттэй энэ тэтгэврийн хэмжээг барьдаг энэ индексжүүлэлтийнхээ асуудлыг яг ямар заалтаар яаж энэ хууль дээр оруулсан юм бэ?

Тэгээд дээрээс нь бас нэг тодорхой асуулт асууя. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг сая энэ 1 сарын 1-нээс ингээд 550000 болчихсон. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бид нар тэтгэврийн доод хэмжээг томьёогоор бодож гаргадаг. Тийм л байсан. Тэгээд тэр томьёогоор бодож гаргавал тэтгэвэр бодолт чинь энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулж үзэх юм бол нэмэгдэх л ёстой. Хэзээнээс энэ нэмэгдэл яг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь нэмэгдсэнтэй холбоотой уягдаж тэтгэвэр нэмэгдэх вэ гэдэг нэмэгдэх үү? Нэмэгдэхгүй юу гэдэг нэг ийм асуултыг асууя.

Дараагаар нь энэ тэтгэврийн сан гээд яриад байна. Энэ дээр Тэтгэврийн нөөц сан гээд энэ бодлогын бичиг баримтад байгаа… /минут дуусав/

П.Анужин: Өнөрбаяр дарга 2 номерын микрофонд хариулт өгье.

Туваан гишүүний асуултад хариулъя. Өнөрбаяр. Нэлээд олон асуултад товчхон хариулаад явчихъя. Хуваарилалтаасаа хуримтлал руу бид нар ялангуяа

төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого дээр туссаны дагуу бид нар 79 оноос хойш төрсөн хүмүүс бас энэ тогтолцоо руу явъя гэдэг ийм томьёоллоор бас бичсэн. Ингэсэн тохиолдолд бид нар бас тооцоонуудыг хийж үзэхэд улсад олон жил ажилласан, өндөр шимтгэл төлсөн ийм хүмүүст тэтгэвэр нь илүү өндөр тогтоогдоно. Илүү ашигтай байгаа.

Харин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр буюу тийм ээ багаар төлж байгаа ийм хүмүүс дээр бол сайн дураар төлж байгаа хүмүүсийн тохиолдолд бас буурах магадлалтай. Гэхдээ энэ тохиолдолд бас яг энэ эрсдэлийг бас төр хариуцаад явах нь зүйтэй юм гэсэн ийм томьёоллуудыг бид нар бас ярьсан асуудал байгаа.

2029 оноос эхлээд юм уу ер нь юу, тэтгэврийн бодолтыг ингээд цаашдаа 20-оос дээш жил ажилласныг 2 хувиар бас нэмэгдүүлэх ийм бодлого баримталж байгаа. Энэ бодлого насжилттай холбоотой. Хүмүүсийн хөдөлмөр эрхлэх олон жил хөдөлмөр эрхлэх энэ бодлогыг нь дэмжих бодлоготой уялдаатай байгаа. Энэ тохиолдолд бид нар бас тооцоо судалгаа хийгээд үзэхэд 1 жилд нэг 700 орчим сая төгрөг гарахаар байгаа. Үүнийг сан өөрөө хариуцаад явах тийм бүрэн боломжтой гэж бид нар бас үзсэн.

Тэтгэврийн нэмэгдэлтэй холбогдуулаад бас тэтгэврийн бодолтын болон улсад ажилласны шимтгэл төлсний шударга байдал алдагдсан гэдэгтэй санал нэг байгаа. Тэгэхээр үүнийг бид нар энэ хуулийн томьёолол дээр ирэх жил нь тэтгэврийг индексжүүлээд энэ тэтгэврийн зөрүүг арилгах бодлогыг бас хамтад нь оруулж ирсэн. Ингэснээр өөрөөр хэлбэл нэг 70 гаруй мянган тэтгэвэр авагчдын тэтгэвэр бас буурсан буюу сайн нэмэгдээгүй гэж хэлэх юм уу ийм нөхцөл байдал байгаа. Үүнийг тэтгэврийн зөрүү арилгахаар бас шийдэгдэх боломжтой. Одоогийн бидний баримталж байгаа энэ индекс 2011 оны суурьтай 2014 онд баталсан ийм итгэлцүүрийг бид нар бас баримталж яваа.

Шинэ хууль батлагдсанаар бид нар энэ шинэ хуулийн 22 дугаар зүйл дээр итгэлцүүрийн асуудлыг бас нарийвчлаад тусгаад өгчихсөн. Хэрвээ энэ хууль батлагдвал цаашид ямар нэгэн тийм тэтгэврийн зөрүү үүсгэхгүй байх ийм нөхцөл байдлыг бид нар хуулийн томьёоллоор оруулж ирсэн гэдгийг хэлье.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 550000 төгрөг болсон. Хууль дээр та бас сайн мэдэж байгаа. Бүрэн тэтгэврийн доод хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувь, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 50 хувь гэсэн ийм томьёололтой байгаа. Энэ томьёоллоо бас бүрэн хангаад аваад үзвэл бүрэн тэтгэврийн доод хэмжээ 375 байхаар байгаа боловч бид нар 500000-аар өөрөөр хэлбэл бүрэн тэтгэврийн доод хэмжээ явж байгаа. Хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ нэг 275000 орчим байх ёстой боловч бид нар 400000-аар ингээд бодолт хийгээд явж байгаа гэдгийг хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Анужин: Туваан гишүүн тодруулна.

Ц.Туваан: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс боддог чинь тийм 75 нэмэх нь гээд нэг юм байдаггүй бил үү. Би буруу бодоод байна уу? тэгвэл нэг түүн дээр миний буруу бодсон юм байна. 350 тэрбум төгрөг гээд оруулаад ирчхэж. Энэ чинь их мөнгө шүү дээ. Үүнийгээ ер нь бас энэ хууль батлагдлаа гээд төсөв дийлэх үү? энэ төсөв чинь ер нь нэлээн хүнд яваад байгаа шүү дээ. 300 дээр нэмэх нь нэг тавиад тэрбум төгрөг гээд орж ирж байна шүү дээ. 290 хэд дээр нэмэх нь. Тэгээд

ер нь энэ чинь 350 орчим орчим тэрбум төгрөг байна шүү дээ. Энэ дээр нэг хариулт авчихъя.

Дээрээс нь энэ тэтгэврийн зээл гээд нэг айхтар юм байгаа. Нэг хэсэг яамнаас билүү ЗГ-аас энэ тэтгэврийн зээл авах дээр 6 сараас дээш өгөхгүй гээд л ингээд хориг тавьж байсан. Яг өнөөдрийн байдлаар энэ тэтгэврийн зээлтэй хэдэн хүн байна, ямар хугацаанд хэдэн хувийн хүүгээр энэ зээл олгогдож байна.

П.Анужин: Өнөрбаяр дарга хариулъя, 2 номерын микрофоныг өгье.

Г.Өнөрбаяр: Туваан гишүүний асуултад хариулъя. Сая таны тэр 300 хэдэн тэрбум гэдэг ямар учиртай тоо вэ гэхээр бид нар албан журмаар даатгуулж байгаа даатгуулагчийн нэг, нэг хувийг өөрөөр хэлбэл тэтгэврийн нөөц санд байршуулахад нэг 291 орчим тэрбум төгрөгийн өөрөөр хэлбэл хуримтлал үүсэх юм гэдэг үүнтэй холбоотой бас тооцоо юм. Нөгөөдөх нь малчдын 5 жилийн шимтгэлийн 50 хувийг 5 жилийн хугацаанд төр хариуцаад явахтай холбоотой ийм тоо гэдгийг бас хэлье.

Тэтгэврийн зээл тэглэсэнтэй холбогдуулаад шийдвэр гаргаснаас хойш өнөөдрийн байдлаар 197000 орчим ахмадууд маань 488 орчим тэрбум төгрөгийн бас зээлийг арилжааны банкнуудаас авсан байна гэсэн ийм сүүлийн Монголбанкны статистик тоо мэдээлэл байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Анужин: 2 номерын микрофоныг өгье.

Г.Өнөрбаяр: Монголбанкны мэдээллээр 197000 тэтгэвэр авагч 488 тэрбум төгрөгийн зээл авсан байна лээ.

П.Анужин: Бадарчийн Жаргалмаа гишүүн хуулийн төсөлтэй холбоотой асуулт асууна.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. 2020 оны сонгуулиас хойш миний мэдэхийн тийм ээ, олон нийтийн хүлээж байгаа гол хууль энэ. Тэтгэвэр нийгмийн даатгалын тухай хууль байгаа. Бид ч гэсэн мөрийн хөтөлбөртөө тэтгэвэр нэмнэ, нийгмийн даатгалын шинэчлэлийг хийнэ ээ гэдэг энэ амлалт авч гарч ирсэн. Яалт ч үгүй энэ парламентад сууж байхдаа энэ нийгмийн даатгалын шинэчлэлийг хийчих юм сан гэсэн зорилго зорилт бидний хэн хэнд маань байгаа байх гэж бодож байна.

Хэд хэдэн зүйлийг асууя гэж бодож байна. Яг өнөөдрийн байдлаар нийгмийн даатгалын сангийн өр ямар хэмжээнд байгаа вэ? Өр барагдуулалтын талаарх мэдээллийг 1 дүгээрт өгөөч.

2 дугаарт, нэг групп байгаа. Хөдөлмөр магадлах комисс энэ хөдөлмөр магадлах комисст нэг хяналт тавиад шалгалт хийсэн үү? Өөрөөр хэлбэл яг групп тогтоолгох хүмүүс тогтоолгож чадаж байна уу? үгүй юу? Яагаад. Би ч өөрөө групп авч байсан. Миний өвчний оношоор 3 жилийн хугацаанд групп аваад би группээс цуцлагдсан. Гэтэл надтай адилхан оноштой хэр нь групп аваад л яваад байдаг ийм улсууд байдаг. Энэ дээр хяналт тавих тогтолцоо маань бүрэн хэмжээнд байж чадаж байна уу үгүй юу гэдэг зүйлийг 2-т асууя.

Сайн дурын давхар даатгалтай байх тэр боломжийг энэ хуулиар нээж өгсөн үү? Хувийн тэтгэврийн сан бүрдүүлэх ёстой гэдэг Учрал гишүүний өргөн барьсан

хуулийн төсөл чинь бас явагдаж байсан. Бид нар хэлэлцэж байсан. Яг үнэхээр бид нар бас энэ боломжийг олон түмэндээ нээлттэй байлгах тэр боломж энэ тийм ээ, ерөнхий хуульд байгаа юу, үгүй юу гэдэг асуултыг асууя.

Түрүүн асуулаа. Өвлөгддөг эсэх. Бид тэтгэврээ төлдөг. Жартайдаа тэтгэвэртээ гараад тэтгэврээ 1 сар аваад бурхны оронд явчихдаг ийм тохиолдлууд кэйсүүд маш их байдаг. Тэгвэл энэ дээр өвлөгддөг эсэх асуудлыг хэрхэн яаж хийх вэ?

Би Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүний хувиар хөгжлийн бэрхшээлтэй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асуудлаар тэдгээрийг асран хамгаалж байгаа эцэг эхчүүдийн асуудлаар үе үеийн сайд нартай удаа дараа уулзаж асуудал тавьж байгаа. Энэ дээр хүнд төлбөрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч байгаа ижий аавд бас тэтгэвэр олгох энэ асуудлыг бас шийдэж өгөөч ээ гэдэг ийм зүйл ярьсан. Хуулийн төсөлд маань энэ асуудал орсон уу үгүй юу гэдэг асуудал.

Нөгөөтээгүүр нэгэнт тэтгэмжийн асуудал яригдаж байгаа юм чинь 16 хүрэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ижий аав тодорхой хэмжээний тэтгэмж очоод хүүхэд нь 18 нас хүрээгүй байж байж 16 нас хүрээд тэтгэмж авахаа больчихдог. Үүнийг нөгөө 0-18 хүртэлх насны хүүхэд гэдэг хуулийн нэр томьёоллоороо 18 нас хүртэл нь энэ хүүхдүүдэд тэтгэмж олгодог байвал ямар вэ гэдэг саналыг бас тавьж байсан. Энэ асуудал маань орсон уу? Нэгэнт олон нийтийн хүлээлттэй байгаа энэ сэдэв энэ хуулийн төсөл орж ирж байгаа энэ цаг мөчид мэдээллээ нэгдсэн нэг байдлаар нэгдсэн цонхоор нэг өгөөрэй гэдгийг би хүсэх байна. Өөрөөр хэлбэл ямарваа нэгэн байдлаар мэдээллийн зөрүүтэй байдлаас олон нийтэд бас тийм ээ, маргаан үүсгэх, дэгдээх сошиал орчинд асуудал дэгдээх, дэврээх ийм нөхцөл байдал үүсдэг учраас Нийгмийн хамгааллын яаманд мөн Байнгын хорооны гишүүддээ ч гэсэн би бас хэлэхийг хүсэж байна. Өөрөөр хэлэх юм бол нэг цонхоор мэдээллээ өгөөч ээ гэдэг зүйлийг хүсье.

Би бас энэ нэг зүйлийг ерөнхий хуулийг харж байгаад бас нэг зүйлийг харлаа л даа. Олимп, тивийн наадам дэлхийн зэрэглэлийн болон улс, орон нутаг, бүсийн тэмцээнд оролцсон тамирчин, түүний дасгалжуулагч олгосон мөнгөн шагналын урамшууллаас шимтгэлээс нь чөлөөлнө өө гэсэн зүгээр би нөгөө өнөөдөр дөнгөж сая гар дээрээ хуулийн төслөө авсан учраас энэ нэг заалтыг харлаа. Энэ дээр урлаг соёлынхон маань маш их гомдол тавьдаг тийм ээ. Бид нар ч гэсэн олон улсын тэмцээн уралдаанаас улс орныхоо нэрийг гаргаад шагнал урамшуулал аваад ирдэг. Энэ дээр бас ийм шимтгэл авагддаг. Энэ дээр бид нар энэ дэмжлэгийг бас хийж өгөөч гэдэг ийм хүсэлтийг тавьдаг. Энэ дээр ер нь ямар зохицуулалт хийж байгаа бол оо гэдэг зүйлийг асуух гэсэн юм. Хэд хэдэн асуулт тавьсан. Энэ асуултынхаа хариулт дээр эргээд дахиад асууя. Баярлалаа.

П.Анужин: 2 номерын микрофонд Өнөрбаяр дарга хариулъя.

Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Өнөрбаяр. Монгол Улс бол олон давхаргатай төрийн тогтолцоотой байна гэж бид нар бас оруулж ирж байгаа. 3 дахь давхарга нь хувийн нэмэлт тэтгэврийн тэтгэвэр байгаа. Энэ тохиолдолд бид нар шууд өвлөгдөхөөр хуулийн төсөл бас бичигдсэн байгаа гэдгийг 1 дүгээрт хэлье.

Цаашдаа бид нарын нэрийн данс ингээд мөнгөжөөд бодитой мөнгө болсон тохиолдолд энэ бас цаашдаа өвлөгдөхөөр ийм хуулийн төслийн зохицуулалт бас хийгдсэн байгаа гэдгийг хэлье. Сүүлийн манай судалгаагаар энэ өнгөрсөн оны эцсийн байдлаар нийт улсын хэмжээнд нийгмийн даатгалын авлага нэг 367.3 тэрбум төгрөг байгаа. Үүний 364 тэрбум нь ААН байгууллагаас, 2.5 тэрбум нь төсөвт байгууллагуудаас авахаар бас ийм мөнгөн дүн бас байгаа гэдгийг хэлье.

Бид нар энэ нийгмийн даатгалын ерөнхий хууль дээр оруулж ирж байгаа бас нэг чухал зүйл энэ групп тогтоолттой холбоотой бас нэг шинэ зүйлийг оруулж ирж байгаа. Энэ нь энэ хөдөлмөрийн чадвараа алдсан бид нарын ярьдгаар энэ группт тогтоогдсон хүмүүсийг нөхөн сэргээх, эмчлэх асуудал хамгийн чухал юм. Одоо бол групп тогтоогоод ингээд яваад байдаг. Бусад улс орны жишгийн дагуу энэ хүмүүсийг аль болохоор эмчлэх, нөхөн сэргээх, буцааж хөдөлмөр эрхлэх боломжуудыг нь хангаж өгөх энэ бодлогыг баримталдаг. Энэ хүрээнд бид нар энэ хуулийн төсөл дээрээ нийгмийн даатгалын дэргэд одоо байдаг эмнэлгийг ажиллуулахаар бас оруулж ирсэн. Манайх хөдөлмөрийн аюулгүй байдал ЭМТ-ийн дэргэд бас ийм эмнэлэг байдаг. Энэ эмнэлгийг нийгмийн даатгалын дэргэд ажиллуулаад энэ нөхөн сэргээлт дээр нь анхааралд явбал хүмүүсийг аль болохоор хурдан хугацаанд нөхөн сэргээх, энэ групп тогтоолт дээр нь хяналт тавих, хөдөлмөр эрхлэх боломжуудыг нь нээж өгөх ийм боломжуудтай гэж бид нар бас үзсэн гэдгийг хэлье.

Та өмнө нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн аав, ээжүүдтэй бас манай яамтай хамтраад олон удаагийн уулзалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан. Энэ уулзалт хэлэлцүүлгийн хүрээнд ялангуяа энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ хараад гэртээ ажил хөдөлмөр хийж чадахгүй байгаа эцэг эхчүүдийн аль нэгнийх нь НДШ-ийг бас тэтгэврийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах гэдэг ийм санал хүсэлтүүдийг бас олон удаа тавьсан. Үүнийг бид нар хуулийн төсөлд оруулж ирээд хүнд хэлбэрийн хүүхдээ хараад гэртээ байгаа ажил хөдөлмөр хийж чадахгүй байгаа эцэг эхчүүдийн аль нэгнийх нь тэтгэврийн даатгалын шимтгэлийг нь төр хариуцахаар хуулийн төсөлд оруулж ирсэн гэдгийг бас танд дуулгая.

Тэр олон улсын уралдаан тэмцээний нэг удаагийн өөрөөр хэлбэл шагналын шинжтэй учраас эндээс ямар нэг НДШ авахгүй ээ гэдгийг бас хэлье. Анхаарал тавсанд баярлалаа.

П.Анужин: Жаргалмаа гишүүн тодруулъя.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Түрүүн та хэллээ. Тийм ээ. Төрийн байгууллагуудаас авах үүрэг байгаа гэж. Тэр өрний асуудлыг хэллээ. Ер нь нөгөө хуулиараа хийгдэж байгаа Капитал банкнаас Капитал банк тийм ээ. Тийм, авах өрийн асуудал хэрхэн ямар хэмжээнд шийдэгдэж байна вэ? Үүнийг яг нарийн тооцоолох бас өгөөч. Баярлалаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ижий аав нь бас тэтгэврийн асуудлыг тодорхой хэмжээнд төрөөс даах зохицуулалт хийгдэж байгаа дээр.

Нөгөөтээгүүр түрүүн нөгөөдөх зарим нэг ганц 1 сарын зөрүүтэй төлөгдөөгүй нэг ийм зохицуулалт юмнууд байдаг. Тийм ээ. Тэгээд үүнийг нөхөн төлөх тэр боломжийг бид нар нэг удаагийн зохицуулалтаар хийж өгөх боломж байгаа болов уу. Тэгээд мэдээллээ нэгтгэе ээ гэдэг зүйлийг би бас дахиад хэлье.

Нөгөөтээгүүр ажлын хэсэгт орж ажиллах саналаа бас Байнгын хорооны даргад хэлье.

П.Анужин: Өнөрбаяр дарга аа, сая бас Жаргалмаа гишүүний хэлж байгаа саналыг би бас өмнө нь та бүхэнд хэлж байсан. Энэ чухал хууль хэлэлцэгдэх үед мэдээллийг нэгтгэж тийм ээ. Нэг цонхоор зөв мэдээллийг өгөх энэ хариуцлагын асуудал маш чухал байгаа юм. Тэгээд үзүүр сэжүүр нь баригдахгүй энэ сошиал орчинд үнэн худлаа хуулийн тайлбар явахаар энэ өөрөө ингээд хэлэлцэгдэж байгаа хуульд ямар их одоо тийм ээ, хортой нөлөө үзүүлдгийг та бид мэдэж байгаа учраас энэ тал дээр тус яам онцгой анхаарч ажиллахыг бас удаа дараа та бүхэнд сануулж байгаа. Тэгээд энэ дээрээ бас анхааралтай ажиллахыг та бүхнээсээ бас хүсье.

Содномын Чинзориг гишүүн асуулт асууна. Нэмэлт асуултад хариулъя. Өнөрбаяр дарга 2 номерын микрофон.

Г.Өнөрбаяр: 2 асуулт асуулаа. Сүүлийнхэд нь би хариулчихъя. Нөгөөдхөд нь яг хариуцаж байгаа хүмүүс нь хариулах байх.

Нөхөн төлөхийг ерөнхийдөө нийтийг хамарсан нөхөн төлөлтийг бид нар хуулийн төслөөр хориглож байгаа гэж түрүүн хэлсэн. Харин тодорхой тохиолдлууд нөхөн төлөхийг зөвшөөрнө. Энэ нь ямар тохиолдол вэ гэхээр ажил олгогч даатгуулагчийн шимтгэлийг хугацаандаа төлөөгүй бас нөхөн төлөх, сайн дураар даатгуулагчийн гэрээндээ бас хугацаагаа төлөөгүй гэдэг ч юм уу. Хууль бусаар ажлаасаа халагдсан хүмүүсийн НДШ бас нөхөн төлөгддөг байх, хилс хэргээр хоригдсон, мөрдөгдсөн ийм тохиолдлуудад нөхөн төлөгдөнө гээд тодорхой кэйсүүд дээр л бид нар нөхөн төлөлтийг зөвшөөрнө. Түүнээс биш бусад нийтийг хамарсан олон жилийг хамарсан ийм нөхөн төлөлтийг бид нар Монгол Улс цаашдаа хэрэгжүүлэх нь зохимжгүй ээ гэж бас үзэж байгаа гэж хэлэх гэсэн юм. Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Анужин: 3 номерын микрофонд нэмэлт хариултыг өгье.

Сайн байцгаана уу. НДЕГ-ын санхүү бүртгэлийн газрын дарга Даваахүү. Капиталын эрх хүлээн авагч томилогдсоноос хойших хугацаанд тооцоо нийлсэн 104.2 тэрбум төгрөг нэхэмжилсэн. Энэ хугацаанд нийтдээ 34.7 тэрбум төгрөгийн төлбөр яг өнөөдрийн байдлаар барагдаад байна. Үүнээс 9.7 тэрбум төгрөг нь мөнгөөр, 25 орчим тэрбум төгрөг нь хөрөнгө хүлээн авч авлагаа барагдуулж,12 дугаар сарын 31-ний байдлаар 69.4 тэрбум төгрөгийн эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн төлбөрийн үлдэгдэл байгаа. Энэ төлбөрийг барагдуулахтай холбоотойгоор капиталын эрх хүлээн авагч Монголбанк, шалгагдаж байгаа хууль хяналтын байгууллагад тодорхой мэдээллүүдийг өгөх, мэдээлэл авах ийм байдлаар ажиллаж байна. Мөн капиталын эрх хүлээн авагч Капитал банканд бүртгэлтэй байсан хөрөнгийн хувьд яг өнөөдөр маргаангүй байгаа хөрөнгүүдийг зарагдах боломжтой энэ хөрөнгүүдийг судлах ийм ажлууд бас хийж байгаа. Гэхдээ яг өнөөдрийн байдлаар яг бид нарт жагсаалтаар ирээд … /минут дуусав/

П.Анужин: Хариултаа гүйцээж өгье. 3 номерын микрофоныг нээе.

Б.Даваахүү: Яг өнөөдрийн байдлаар бид нарт хөрөнгө хэлбэрээр жагсаалтаар ирчхээд байгаа энэ хөрөнгүүдийн хувьд шууд хүлээж авах боломжгүй байна гэсэн ийм нэг бүрчлэн үзэж танилцаад одоо байгаа хөрөнгүүдийг авах

боломжгүй байна гэсэн ийм хариулт өгчихөөд байгаа. Хууль хяналтын байгууллага шалгагдаж дуусаны дараа маргаантай хөрөнгүүд болоод бусад одоо өмнөх хугацаанд АТГ-аас бас зарлаж байсан хөрөнгүүд байгаа. Банкны эх үүсвэрээр бий болсон байж болзошгүй гэж шалгагдаж байгаа гэсэн хөрөнгүүд байгаа гэсэн ийм мэдээллүүд өгсөн. Энэ хөрөнгүүд дээр дахиж үзэж судлах, төлбөрөө барагдуулах ийм ажил хийхээр ажиллаж байна.

П.Анужин: Жаргалмаа гишүүний саяын асуулт асуусан асуулттай холбоотойгоор хэлэхэд ирэх 7 хоногийн Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлуудын дараалалд энэ Капитал банктай холбоотой өр барагдуулалтын асуудлыг бид нар сонсох юм байгаа юм. Энэ дээр бид нар бас энэ хуулийг хэлэлцэж байх үед зайлшгүй ярилцаж бас нийгэмд тодорхой мэдээлэл өгөх шаардлагатай учраас ирэх 7 хоногийн Байнгын хорооны хэлэлцэх асуудлын дараалал байгаа гэдгийг хэлье.

Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

С.Чинзориг: Би асуулт ч асуухгүй. Зүгээр үг хэлчихье. Нөгөө зовлон нэгтэй улсууд байна даа, энэ хэдийг байцаагаад л өөрөө нэг их байгаагүй юм шиг олон юм яриад байлтай биш. Тэгэхээр 2, 3 юм байгаа юм аа, Аюурсайхан сайд аа. ЗГ үйл ажиллагааны хөтөлбөрт нэг сонин томьёолол орчихсон юм. НДШ төлөгч иргэн залуучуудыг урьдчилгаа төлбөргүй орон сууцаар хангана гэсэн нэг юм орчихсон хаанаас явж байгаад орчихсон юм. Түүнийг та бүхэн маань ер нь бодож байгаа юу, үгүй юу. Энэ хуультай холбоогүй л дээ. Гэхдээ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тийм байгаа юм. Нийгмийн даатгал шимтгэл төлөгч бол урьдчилгаа төлбөргүйгээр орон сууцжуулах ийм бодлого хэрэгжүүлнэ ээ гэсэн. Үүнийг та бүхэн маань ер нь харж байна уу? Харахгүй байна уу. 1 дэх асуудал.

2 дахь асуудал. Энэ тэтгэврийн зөрүүтэй холбоотой юман дээр гишүүд ер нь бид цаашид ер нь яах ёстой юм, тэтгэврийн зөрүү бол энэ үнийн өсөлт инфляцын түвшинтэй уялдаж гараад байгаа. Ний нуугүй хэлэхэд 90 оноос хойш гарсан энэ үнийн өсөлт инфляцынхаа түвшинг манай цалингийн өсөлт гүйцэхгүй яваад байгаатай холбоотой л ийм тэтгэврийн зөрүү гэсэн юм гараад байх юм. Тэгэхээр ер нь шимтгэл төлж байсан хугацаанаасаа үл хамаараад л адил хэмжээний үнэлэмжтэй ажил албан тушаал эрхэлж байсан бол тэтгэвэрт гарсан хугацаанаас үл хамаараад л ойролцоо тэтгэвэртээ байх тухай асуудлыг л тэтгэврийн зөрүү л гэж уг нь ойлгож яриад байгаа юм. Тэгэхдээ хуульд бас ийм юм байдаггүй. Гэхдээ бас амьдрал дээр байгаа учраас бас үүнийг арилгах ёстой гэж. Ийм нэг юмтай холбогдож зөрүү гараад байгаа юм.

2 дахь юм нь ер нь манайхан цаашдаа бас ярьж баймаар байгаа юм. Энэ яамныхан. Тэтгэвэр бодож байгаа аргачлалтайгаа холбоотой бид бас ийм нэг тэтгэврийн зөрүү бас гаргаад байгаа юм. Одоо хөдөлмөрийн гэрээгээр заавал даатгалд хамрагдаж байгаа иргэн төлж байсан шимтгэлийн тэтгэвэрт гарахдаа 2,5-4 дахин нэмэгдүүлээд тэтгэвэр болгоод аваад байгаа байх. Тийм ээ, Ганцэцэг ээ. Тэр хавьцаа л байгаа байх. Тийм байгаа. Тийм л дунджаар тийм л байгаа 2,5-4 дахин нэмэгдүүлж тэтгэвэр болгож авч байгаа юм. Гэтэл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс сайн дураар шимтгэл төлж байсан иргэн болбол төлж байсан шимтгэлээ 10 дахин нэмэгдүүлээд тэтгэвэр авчхаад байгаа юм. Тэтгэвэр аваад байгаа юм. Тэгэхээр үүнээс чинь хамаараад бас тэтгэврийн зөрүү ойлгоод би тэр хувиар сайн дураараа хөдөлмөрийн доод хэмжээнээс шимтгэл төлж байсан хүнтэй адилхан тэтгэвэр авч байна гэдэг бас асуудал гараад байгаа юм. Тэгэхээр энэ нэг

нь заавал даатгалд хамрагдаж байсан иргэн шимтгэлийн 2,5-4 дахин нэмэгдүүлж тэтгэвэр болгож авдаг, сайн дураар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс шимтгэл төлөөд тэтгэвэр авч байгаа хүн тэр шимтгэлийг нь төлсөн шимтгэлээ 10 дахин нэмэгдүүлээд тэтгэвэр болгоод аваад байгаа учраас бас ийм асуудлууд байгаа юм. Тэгээд ийм 2 асуудлаас үүсээд энэ тэтгэврийн зөрүү гэсэн асуудал гараад байгаа. Үүнийг бас хэлэлцүүлгийн явцад ярьж байгаад энэ тэтгэвэр бодох аргачлалтай холбоотой юмыг засах уу яах вэ гэдэг юмыг бас бид бас хармаар байгаа юм.

3 дахь юм нь хамгийн гол санаа зүгээр яах вэ тэр тэтгэврийн зөрүү арилгахтай холбоотой нэрийн дансыг мөнгөжүүлэхтэй холбоотой юм. Тэгэхээр засаг төр байгаа юм. Тэгээд нэг яаж хийж байгаад нэг хугацаа нь их л хойшоо тавигдах байх. Тэгээд нэг мөнгөжүүлж таарах байх. Ирэх жил энэ тэтгэврийн зөрүүг индексжүүлж, тэтгэврийн зөрүү арилгаж байж энэ тэтгэврийн шинэ хуулийг хэрэгжүүлэхгүй л энэ цаашаа явахад хэцүү шүү дээ. Хамгийн гол нь энэ сангийн менежментийг яаж сайжруулах юм, засаглалыг яаж сайжруулах юм, менежментийг нь хэн хийх юм. Тэгээд энэ чөлөөт үлдэгдлийн тэр 2 хувийг ч гэсэн хуримтлал үүсгэнэ л гээд байгаа юм, үүнийгээ хэн тэр хуримтлал үүсгэх энэ зохицуулалт менежментийг хийх вэ гэдгийг л бид нар сайн бодмоор байгаа юм. Үүнийгээ л засаглалаа сайжруулж чадахгүй бол энэ хэчнээн ч сайхан юм хийгээд байвал энэ цаашаа явахгүй. Тийм учраас миний хамгийн гол санаа зовоож байгаа юм засаглалыг яаж сайжруулах вэ. Энэ хөрөнгө … /минут дуусав/

П.Анужин: Нэмэлт 1 минут өгье. Чинзориг сайдад.

С.Чинзориг: Энэ засаглалыг яаж сайжруулах вэ. Хуримтлалыг хэн хийх вэ. Менежментийг нь яаж хийх вэ гэдэг л бидний санаа зовоосон асуудал байгаа. Би ч гэсэн бас сайдаар ажиллаж байхдаа эд нартайгаа үүнийгээ хий гээд л нухаад л зөндөө л суусан юм. Тэгээд бас үүнийгээ бас яг нарийн гарц олж чадахгүй л яваад л байдаг байсан юм. 2 дах нь Аюурсайхан сайд нэг анхаарах юм. Цаашдаа тэр мөнгөжүүлэх асуудал чинь хугацааны хувьд их л орой юм байна л даа, 29 оноос хойш. Тэгээд нөгөө баялгийн сан нь гараагүй байдаг. Хуримтлалын сан бий болоогүй байдаг. Тэгээд мөнгөжүүлнэ гэдэг их бүрхэг. Гэтэл энэ иргэдийн шахалтад ороод янз янзын баахан зардал нэмээд л ороод ирлээ шүү дээ. Нөгөө 7 жил гэж байсан 5 болгоод л. Дээр нь тэр эхнэр нөхөр аль нэг нь бурхан болсон бол тэтгэврийнх нь 20 хувийг өгнө энэ тэр гээд л зардал буцаад л асар их нэмэгдэх нь. Гэтэл энэ хуримтлал бий болгох асуудал, тэр мөнгөжүүлэх асуудал чинь их хойшоо тавигдаад, тэгээд бид бас нэг тийм сайхан үр дүнтэй сайхан юм болох уу? Үгүй юу, би бас жаахан эргэлзээтэй л байна.

П.Анужин: Чинзориг сайд санал хэллээ.

Хуулийн төсөлтэй холбоотойгоор гишүүд асуулт асууж дууслаа.

Хэлэлцэж байгаа хуулийн төсөлтэй холбоотой үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Туваан гишүүнээр тасалъя. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлнэ.

М.Оюунчимэг: Нийгмийн даатгалын багц хуульд дагалдаж орж ирж байгаа 5 хууль байгаа. Энэ мэдээж цаг хугацааны хувьд үнэхээр оройтож байгаа. Бид үүнийг батлах чухал. Хамгийн чухал асуудал нь нийгэмд хүлээлт үүсгэж байна. Гэхдээ энэ өөрөө хүн бүхний амьдралдаа шууд нөлөөлөх маш чухал хууль учраас их сайн хэрэгжих хууль ёстой, хэрэгжихийн тулд бүх талын тэр энэ хууль сайн

хэрэгжихээс шалтгаалах зүйлүүдийг бид хэлэлцүүлгийн явцад бүрэн сайн тусгаж байж энэ хууль хэрэгжинэ. Яагаад гэвэл өмнө нь буцсан хууль яг санхүүжилттэй холбоотой тэр үл ойлголцол эсвэл яг хэрэгжих механизмыг нь хөрөнгө мөнгөний тооцоо тэр нь яг тэдэн жил тэдээр тооцно гээд энэ уялдаа холбоо, нарийн тооцоо байхгүй байснаас болоод ингээд буцаж байсан. Тэгэхээр ингээд хэлэлцэх эсэхийг мэдээж дэмжих байх. Би дэмжиж байна. Харин хэлэлцүүлгийн явцад ялангуяа тэр тооцоо судалгаа маш сайн хийж байгаа. Тэгээд энэ хууль гарсны дараа бодит амьдрал дээр сайн хэрэгжээд явах нь л маш чухал байгаа. Түрүүн хэлж байна. Сангийн яам 16 зүйл дээр бас санал өгсөн байна лээ. Тэгээд энэ нь бас л нөгөө санхүүжилттэй холбоотой асуудал.

Тэгэхээр иргэдийн гол хүсэж байгаа юм бол ахмадууд маань тэтгэврийг нэмэгдүүлэхийг хүсэж байна. Одоо энэ тэтгэвэр төлж байгаа залуучууд маань тийм ээ, даатгал төлж байгаа. Нийгмийн даатгал, ЭМД төлж байгаа энэ залуучууд маань би хэдийг төлж байгаа юм. Би үүнийг төлснийгөө ил тод хардаг байх юм сан. Ирээдүйд энэ миний амьдралын баталгаа болоосой гэдгийг хүсэж байна. Тэгэхгүй бол одоо яг төлж байгаа хүмүүс маань ихэнх нь би төлөөд л байдаг. Тэгээд нэг нас ахихаар сая төгрөг олдох уу үгүй юу болоод дуусдаг. Би ийм юмыг төлөхийг чинь хүсэж байна уу, үгүй юу гэдэг асуудал өөрөө өнөөдөр нийгмийн даатгалын энэ багц хуулийг шинэчлэх, нийгмээ дагаад өөрчлөх ийм шалтгаан болж байгаа учраас аль алийг нь залуучуудаа ч, одоо төлж байгаа хүмүүсээ ч, одоо тэтгэврээ аваад байж байгаа ахмадуудаа ч бодолцсон улс орныхоо ирээдүйг бас том тэтгэврийн тогтолцоогоо найдвартай, баталгаатай болгох энэ асуудлууд маш чухал байгаа.

Тэгээд хуваарилалт хуримтлал. Үүнийг бас бид баланстаа авч үзэх хэрэгтэй байгаа учраас ажлын хэсэг дээр маш нухацтай байж ажлын хэсэгт бас хариуцлагатай хүмүүсээ оруулаад ажлын хэсгийг бас би ингээд ороод ингээд ахалж явахыг хүсэж байна.

П.Анужин: Буланы Бейсен гишүүн үг хэлнэ.

Б.Бейсен: Энэ нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийг бас дэмжиж байгаа юм. Тэгэхдээ хэд хэдэн асуудал байна. Энэ та нар өгсөн материал дээрээ дандаа энэ 23 он гарчхаад байна шүү дээ, 19 онтой харьцуулаад юм өгөх юм. 22 онд зарцуулсан юм өгөхгүй байх юм. Ерөөсөө тоо баримтыг нь. Жишээлбэл 19 онд тэтгэврийн даатгалын сангаас 21 онд 456000 тэтгэвэр авагчид 2.3 их наяд зарцуулсан гээд тэгж байгаа, төгрөг. Одоо энэ 22 онд чинь 3.7 их наяд болоод нэмэгдсэн шүү дээ. Танай төсөв. Тэгэхээр чинь 22 онд хэдийг зарцуулсан тэр талын асуудал дээр энэ тодорхой мэдээлэл өгч байгаач ээ гэдгийг хэлмээр байна.

Нөгөө талаар энэ тэтгэврийн сангийн зарцуулалт дээр хуримтлалын тогтолцоогоор явах юм уу, эв нэгдлийн тогтолцоогоор явах юм уу гэдэг асуудал бас байж байна. Хуримтлалын өндөр хөгжилтэй Америкт гэхэд хуримтлалын тогтолцоогоор гэхэд би хуримтлуулсан мөнгөө тэдэн жил давна гэх юм уу, аль эсвэл зээлд зарцуулна гэх юм уу, түүнтэй гэрээ хийх ёстой юм байна. Даатгуулагч даатгагч 2 нэг нэгэндээ гэрээ хийж байгаа. Тэгээд л төчнөөн жил авна гэх юм уу. Одоогоор энэ харж байхад тэтгэврийн зөрүү арилгалаа гээд 500000 болсон тэтгэврийн доод хэмжээг. Гэтэл сүүлийн нэг хэдэн жил хувийн даатгал төлж байгаад насаараа тэтгэвэр авахыг эрмэлзэж байгаа улсууд ч байж байна. Одоогийн тэтгэвэр авагчдын ихэнх гомдол нь би насаараа 30, 40 жил ажиллачхаад

500000 авч байна. Хэдэн жил хувийн даатгал төлж байгаад надтай адилхан тэтгэвэр авч байна гэж байна. Одоо энэ өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт инфляцыг байхгүй. Үнэхээр цалин тэтгэвэр нь хүрэлцэхгүй байна.

Тийм учраас энэ хуулийн төсөл дээр дараагийн юун дээр бас үүнийг зөрүүг нь гаргах асуудал дээр та нар нэг зөв ажиллаж өгөөч ээ гэдгийг хэлмээр байна.

Нөгөө талаар энэ сая нөгөө тэтгэврийн доод хэмжээ 500000 тийм ээ. Хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ гэж бас байж байна. Эд нарын зөрүүг арилгах тал дээр та нарыг хууль баримтлаад сайн ажиллаж өгөөч. Нөгөө талаар сая нэг хуримтлалын тогтолцоогоор явах юм уу, эв нэгдлийн тогтолцоогоор явах юм уу. Гэрээ хийх, даатгуулагч даатгагч гэрээ хийх асуудал дээр ярихгүй бол мөн адилхан хэдэн жил хувиараа тэтгэвэр юу даатгалын шимтгэл төлчхөөд тэгээд насаараа авах асуудал дээрээ яах вэ гэдэг дээр сайн бодож энэ тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулахад энэ дээр анхааараач ээ гэдэг санал хэлмээр байна. Анхаарал тавьсан баярлалаа.

П.Анужин: Булан гишүүнд баярлалаа. Цэвэгдоржийн Туваан гишүүн үг хэлнэ.

Ц.Туваан: Энэ хуулийн өөрчлөлт оруулж ирж байгааг дэмжиж байгаа. Тэгээд тэр үндэслэл хэсэг дээр энэ НДШ төлөлтийг нэмэгдүүлэх гээд маш чухал зүйл л дээ. Бид нар иргэдээ бас энэ аль болох зуун хувь руу дөхүүлсэн байдлаар төлүүлээд, эргээд энэ төлсөн иргэдийн хөдөлмөрийн чадваргүй өндөр настай болсон үедээ бас нийгмийн хамгаалал өөрсдийн нийгмийн баталгаа хангагдах гэдэг асуудал нь аягүй чухал байгаа юм. Тэгэхээр энэ дээр энэ хууль бус энэ зүг рүү чиглэж байгааг дэмжиж байгаа.

Нэрийн дансыг мөнгөжүүлэх гээд. Энэ сая 23 их наяд гээд тоо сонслоо. Энэ бол хол сонсогдож байна. Тэгэхээр энэ дээр бас өмнө нь бас бид нар энэ тэр Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хууль гээд хууль явж байсан. Энэ дээр бас хөөрхөн энэ ипотекийн зээлтэй холбоод гаргалгаа гаргачихсан явж байсан. Одоо энэ хууль дээр болохоор нэг нэг гээд ажил олгогч шимтгэл төлөөлөгч 2-оос ингээд аваад явах юм шиг байна. Энэ тэгээд хэзээ 23 их наядыг хүргэх вэ? Энэ бас нэлээн л хол л сонсогдож байна. Тэгэхээр үүнийг ер нь жоохон тэр дагалдах өшөө тэр баялгийн сангийн тухай хууль энэ тэрүүдээр нь жоохон хурдавчилж байж л энд нэг ойрын ирээдүйд ахиц тодорхой ахиц гарна гэсэн ийм зүйл харагдаж байна.

Тэр тэтгэврийн зээлтэй иргэдийн дунд яриад байгаа нэг асуудал байгаа шүү дээ. Би насаараа шимтгэл төлж, төлж, төлж байгаад эрэгтэй хүн 60 хүрээд жаран нэгтэйдээ нас барчихлаа гэхэд тэр насаараа төрсөн шимтгэлийнхээ одоо дагуу хуулийн дагуу авч байгаа тэтгэврийг 1 жил хүрэхтэй үгүйтэй аваад л ингээд л бурхны оронд явчхаж байна. Тэгээд энэ хүн нас барахынхаа өмнө тодорхой хэмжээний зээлтэй байгаад байдаг. Энэ зээлийг нь банкныхан маш овжиноор ашиглаж зээл олгодог дэвтрийг нь барьцаалаад тэгээд нэг хүүхдийг нь хажууд нь бариад уячихдаг. Тэгээд эргээд энэ зээлийн ямар ч эрсдэлгүй зээл. Тэгэхээр энэ дээр хүртэл энэ банкныхан хараад ингээд мөнгө олоод байна шүү дээ. Тэгэхээр үүнийг энэ хууль энэ тэртэй бас ийм зээлтэй иргэн нас барсан тохиолдолд тэд хүртэл хэмжээний зээлтэй иргэн тэдэн жил авч чадаагүй үед энэ тэр гээд нэг жоохон уян хатан нөхцөл оруулж өгвөл энэ хуримтлал руу юм уу, хагас хуримтлал руу явах гэж байгаа энэ тогтолцоо чинь бас нэлээн бодитой харагдах байх.

Иргэндээ ч гэсэн насаараа төлчихсөн мөртөө гээд гомдоллох байдал нь нэлээн багасах байх гэж ингэж бодож байна.

Тэгээд хуулийн концепц дотор нь бас энэ ерөөсөө л тэр эв санааны нэгдлийн зарчмыг хагас хуримтлал хуримтлал руу оруулах гэдэг энэ зарчим нь зөв байх. Юу гэхээр энэ чинь хүмүүстээ сонголт бий болгож өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл залуучууд хэрвээ тэр өнөөдрийн нийгмийн даатгалд шимтгэл төлж байгаа залуучууд бид нар яагаад заавал өмнөх үеийнхээ юу тэтгэврийг төлөх ёстой гэж гэж асууж их ярьдаг улсуудад тэгвэл та нар нэмэлтээр энэ хувийн тэтгэвэр хуримтлалын энэ тогтолцооныхоо энэ юмандаа хийгээд яв л даа гэдэг энэ сонголтыг нь бас хийж өгч байгаа асуудлыг нь дэмжиж байна.

Тэгээд бас энэ хууль хэлэлцэх явцад ажлын хэсэгт нь орж байгаад бас энэ асуудлуудаа хэдүүлээ нэлээн ултай суурьтай яриад явчихъя гэсэн ийм үгийг хэлье.

П.Анужин: Туваан гишүүнд баярлалаа.

Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя, гишүүд ээ, санал хураалт явуулна. Анхааралтай байгаарай.

83.3 хувиар уг хуулийн төсөл дэмжигдлээ.

Бас Байнгын хорооныхоо гишүүдэд хэлэхэд энэхүү хууль бас өргөн баригдсан даруйд өнөөдөр Нийгмийн бодлогын байнгын хороо авч бас хэлэлцэж байна. Гишүүддээ маш их талархаж байна. Энэ хуулийн төсөл Нийгмийн бодлогын байнгын хорооны нийт гишүүдийн хувьд бас цоо шинэ хуулийн төсөл биш. Уг хуулийн анхны хэлэлцүүлэг нь 2020 оны 10 дугаар сард орж ирж байсан учраас гишүүд маань бас үндсэн бэлтгэл сайтай. Мөн энэ өөрөө мэргэжлийн Байнгын хороо учраас өнөөдөр бас ингэж идэвхтэй хэлэлцэж, үнэтэй саналаа тавьж асуудалд хандаж байгаад бас Нийгмийн бодлогын байнгын хорооны нийт гишүүддээ баярлаж байгаагаа илэрхийлье.

Хэлэлцэх асуудлынхаа дараагийн асуудалд оръё.